

Монгол бичгийн ялгах тэмдэг ба “үсгийн эндүүрлийн харанхуй”

Ж. Лувсандорж*

Хураангуй: Монгол бичгийн ялгах тэмдэгийн хэрэглээний учраар XVIII зууны үед монгол хэлбичгийн мэргэдийн дунд болсон мэтгэлцээн, шүүмжлэл, журамлал, түүний үр дүнг товч тодорхой үзүүлэх зорилгоор энэ өгүүлэлийг бичиж байна. Ийм судалгаа монгол хэл бичгийн түүхийн судлалд төдийгүй, монгол бичгийн одоогийн болон цаашдын дадлагын хэрэглээнд чухалтай гэж зохиогч үзэж байна. Монгол бичгийн γ үсэг өмнөө хоёр цэгтэй байдаг. Үүнд гайхах юмгүй. Гэтэл түүнийг эндүүрэлд тооцож, бүүр “үсгийн эндүүрлийн харанхуй” гэсэн хэллэгээр хурц шүүмжилж байсан тухай энд ярина.

0. Ялгах тэмдэг Монгол бичгийн ялгах тэмдэг¹ гэдэг нь үндсэндээ *čeg*² (халх. *цэг*) юм. Цэг гэдэг нь олон авиаг үсгүүдийг ялган үзүүлэхийн тулд үсгийн өмнө тавих нэг цэг (*dang čeg*), зарим үсгийн өмнө ба хойно тавих хоёр цэг (*dabqur čeg*) байна.

- a) Дан цэгийн үүрэг нь n үсгийн үе эхлэгч дүрийг үе төгсгөгч дүрээс нь ялгахаас гадна, түүнтэй адил зурамаар тэмдэглэгдсэн бусад үсгээс (a, e) ялгах;
- b) Давхар цэгийг q/k үсгийг γ/g үсгээс ялгах (зарим нутагт), эсвэл γ/g үсгийг q/k үсгээс ялгах (зарим газарт), эсвэл зөвхөн γ үсгийг q үсгээс ялгах (тогтсон уламжлал) тэмдэг болгохоор мэтгэлцсэн түүхийн явцад цагаан толгойн дэгүүд гарахад хүрсэн.³
- c) Үсгийн хойно тавих давхар цэг – \check{s} үсгийг s үсгээс ялгах; – ийм гурван зүйлийн цэг хэрэглэж ирсэн юм. Үүнээс гадна,

* Карлын Их Сургууль, Өмнөд ба Төв Ази Судлалын Хүрээлэн

¹ Монгол бичгийн ялгах тэмдэг олон биш. Үсгийн өмнө юмуу хойно тавьдаг *дан ба давхар цэг*, төвөд бичгээс хожим ирсэн *зартис/флажок* (Кара Д., 1972, р. 41), l ба m үсгийн эвэр (Шагдарсүрэн Ц., 2001, р. 46) төдийхөн юм.

² *Čeg/čiy* гэдэг үгийг төвөд хэлнээс ирэхийн өмнө түүнийг *temdeg* ‘diacritic’ (Oyaryui-yin mañi-1, р. 12v), *dusul* ‘dots’ (Цэвэл, Я., 1966, р. 213) гэж нэрлэдэг байв.

³ Монголын бичгийн хэлэндхи ялгах цэгийн хэрэглээний тогтсон журамгүй байдлыг XX зууны эхээр Г. И. Рамстедт ажиглан тэмдэглэсэн нь:

- “Зарим монгол ном сударт үеийн эхэнд (хааяа үеийн эцэст), нармайн γ авиаг, чанга гийгүүлэгчээс ялгахын тулд урд талд нь хоёр цэг тавьж болно.
- зарим тохиолд γ, g хоёроос ялгахын тулд q, k хоёрт цэг тавих юмуу,
- бүүр k, g хоёроос q, γ хоёрыг ялгаж цэгтэй бичих нь ч бас байдаг” (Рамстедт Г. И., 1967, р. 126)

d) *Qoyar čikin*⁴ / *morin-u čikin*⁵ гэдэг ялгах тэмдэг хэрэглэн (XIV зуун) *p* үсгийг *b* үсгээс ялгасан боловч XVIII зуунаас шар малгайтны шашны соёлын түрэлтээр монгол бичгийн хэл II байранд ороход (Владимирцов Б. Я., 1925, р. 451) тэр “*морины чихний*” байрыг төвөд үсгийн *jartiy* (халх. *зармиг*) гэдэг ялгах тэмдэг эзлэн авч бүүр хожим XX зуунаас орос соёлын түрэлт ирэхэд *eber* нэрийг олж *f* (*ф*) үсгийг *b* үсгээс ялгах тэмдэг болсон билээ.

Ялгах тэмдэг – цэгийн олон зуун жилийн санал зөрсөн хэрэглээний үр дүнд Монгол Бичиг нь үсэгзүйн, чухамдаа Цагаан Толгойн хэд хэдэн дэгт хуваагджээ. Өнөө үеийг хүртэл уламжлагдан ирсэн монгол бичгийн хэвлэмэл ба бичмэл бүх утгазохиолыг ялгах тэмдэг хэрэглэсэн байдлаар нь доорхи дөрвөн дэг болгон ангилж болно. Ангилалыг нэрлэхдээ би, монгол бичгийн хэлний зүйчид болон заах аргач багш нарын тогтоосон үеэр нэрлэх уламжлалыг⁶ дагасанаа тэмдэглэе.

1. Монгол үсэгзүйн Цагаан Толгойн дэг⁷

1.1. “*Qa-yin doluy-a*” цэгтэй – *A*. дэг (*ха-гийн долоо цэгтэй*)

Qa-yin doluy-a (*ардын нэрлэлт*) буюу “*qa-yin törül*” (*Ойтартуй-ийн Майи-1*, р. 11v.), “*qa-yin ayimay*” (*Todudqayci toli*, р. 58) гэдэг нь *qa*, *ke*, *ki*, *qo*, *qu*, *kö*, *kü* – энэ долоон үеийг тэмдэглэсэн үе-үсгүүдийн нэр болно.

“Өмнө нь хоёр цэгтэй *h ēth*”⁸ = *q*. Тодорхой үзүүлбэл үе эхлэгч *q* (*qa*, *qo*, *qu*) үсгийн өмнө хоёр цэгтэй.

“Өмнө нь хоёр цэгтэй *kāph*” = *k*. Тодорхой үзүүлбэл үе эхлэгч *k* (*ke*, *ki*, *kö*, *kü*) үсгийн өмнө хоёр цэгтэй.

“Цэггүй *h ēth* = *γ*. Тодорхой үзүүлбэл үе эхлэгч *γ* (*γa*, *γo*, *γu*) ба үе төгсгөгч *γ* үсэг бүгдээр цэггүй.

“Цэггүй *kāph*” = *g*. Тодорхой үзүүлбэл үе эхлэгч *g* (*ge*, *gi*, *gö*, *gü*) ба үе төгсгөгч *g* үсэг бүгдээр цэггүй.

“Өмнө нь нэг цэгтэй *nīn*” = *n*. Тодорхой хэлбэл, үе эхлэгч *n* (*na*, *ne*, *ni*, *no*, *nu*, *nö*, *nü*) үсгийн өмнө нэг цэгтэй, үе төгсгөгч *n* үсэг цэггүй.

“Хойно нь хоёр цэгтэй *šin*” = *š*. Тодорхой хэлбэл, үе эхлэгч *š* (*ša*, *še*, *ši*, *šo*, *šu*, *šö*, *šü*) үсэг долуул хойно нь хоёр цэгтэй.

“*taw*” = *t*. Тодорхой хэлбэл, монголчуудын “*босоо ta*”, “*тариан толгойт ta*” гэж нэрлэдэг *t* (*ta*, *te*, *ti*, *to*, *tu*, *tö*, *tü*) үсэг, бүх байрлалдаа нэгэн утгаар *t* үсгийг тэмдэглэсэн.

⁴ *Bstan-'dzin-grags-pa* (Данзандагва)-ын нэрлэлт (*Oytartuyi-yin Maii-1*, р. 6r.)

⁵ *Bilig-ün Dalai* –ийн нэрлэлт (*Mongyol üsüg-ün tolta...*, р. 5r)

⁶ *Үеэр нэрлэх уламжлал* Монгол бичиг уг нь 14-хөн үсэгтэй авианы бичиг юм. Гэтэл номын хэлийг журамлагчид нь үе-үсэгтэн (төвөд бичгийн хэлтэн) байсан тул монгол үсгүүдийг энэхдэг-төвөдийн үе-үсгийн цагаан толгойн аргад шилжүүлэн монгол хэлний 7 эгшгийг дэслэх тогтсон дэсийг (*a*, *e*, *i*, *o*, *u*, *ö*, *ü*) ашиглан, нэг гийгүүлэгч үсгийг 7 эгшгээр хувилгаж (“*па-гийн долоо*” : *na*, *ne*, *ni*, *no*, *nu*, *nö*, *nü*) гэх мэт нэрлэх уламжлалыг тогтоов. Ингээд жишээ нь “*па-гийн гуравдугаар үсэг*” гэвэл *ni* гэж мэдэх арга тогтсон юм.

⁷ Монгол бичгийн гарамгай судлагч Д. Кара, “четыре разные школы классической орфографии” гэв (Кара, Д., 1972, р. 70). Тэдгээр дэгүүдийн баримталдаг зөв бичихзүйд зөрүү байхгүй, зөвхөн цагаан толгойн үсэглэвэр зөрөөтэй тул Цагаан Толгойн дэг гэж нэрлэх нь оновчтой биз. Үзэмүү: дагалт – 1.

⁸ Монгол үсгийн эх болсон согд-уйгур үсгийн галиг, нэр томьёоны тухай (Шагдарсүрэн Ц., 2001, р. 44, Владимирцов Б. Я., 1989, р. 71) номуудад лавлан үзнэ үү (үз дагалт-2а, 2б.).

“dāleth” = *d*. Тодорхой хэлбэл, монголчуудын “хэвтээ *da*” гэж нэрлэдэг *d* (da, de, di, do, du, dō, dü) үсэг, бүх байрлалдаа нэгэн утгаар *d* үсгийг тэмдэглэсэн ба тайлагдал: үе төгсгөгч *d* үсгийг согд-уйгурын үгийн эцсийн “*taw*” үсгийн хэлбэрийг бага зэрэг өөрчлөн *гэдэс+шүд/сүүл* (үз дагалт-3) болгосон.

“*sādhe*” тэмдгийг *č* үсэг болгож, хэлбэрий нь жаахан өөрчлөн (өнцгий нь мохоо болгосон) үгийн дундхи байрлалын *j* (дж) үсэг хийсэн.

Энэ дэг өмнөд монгол болон буриад нутагт их дэлгэрсэн (Шагдарсүрэн Ц., 2002, р. 230). Гол дурсгал нь XVIII зууны эхэн хагаст хэвлэгдсэн бээжин барын “*Jirūken-ü tolta-yin tayilburi Üsüg-ün Endegürel-ün Qaranγui-yi arilyaγci Oγtarγui-yin Mañi kemekü orušiba*” (1727) гэдэг хэл бичгийн судар. Энэ дэгийн хэвлэлийг үзээд ар монголчууд “*qa/ke цэгтэй судар*” гэгцгээнэ.

1.2. “*Ga-yin doluy-a*” цэгтэй – Б. дэг (*га-гийн долоо цэгтэй*)

“*Ga-yin doluy-a*” буюу “*γa-yin törül*”, “*γa-yin ayimaγ*” гэдэг нь *γa, ge, gi, γo, γu, gō, gü* – энэ долоон үеийг тэмдэглэсэн үе-үсгүүдийн нэр болно.

“Өмнө нь хоёр цэгтэй *hēth*” = *γ*. Тодорхой үзүүлбэл үе эхлэгч *γ* (*γa, γo, γu*) үсгийн өмнө хоёр цэгтэй.

“Өмнө нь хоёр цэгтэй *kāph*” = *g*. Тодорхой үзүүлбэл үе эхлэгч *g* (*ge, gi, gō, gü*) үсгийн өмнө хоёр цэгтэй.

“Цэггүй *hēth*” = *q*. Тодорхой үзүүлбэл үе эхлэгч *q* (*qa, qo, qu*) цэггүй.

“Цэггүй *kāph*” = *k*. Тодорхой үзүүлбэл үе эхлэгч *k* (*ke, ki, kō, kü*) үсэг цэггүй.

n ба *š, č, j* (дж) үсгийг тэмдэглэх арга нь А. дэгийн адил.

t ба *d* үсгийг тэмдэглэх арга нь сонгодог (одоогийн) монгол бичгийн адил

Энэ дэг өмнөд ба зүүн монголд дэлгэрч байсан бололтой. Дурсгалт бичгийн жишээнд “*Mongγol üsüg-ün tolta-ača öcüken jiyaburi bolai*”, “*Mongγol üsüg-ün ilyal ba taqabodun öcüken tobči-niyud bolai*” гэсэн нэртэй жижиг судрууд (2.2.5. үз) ба алдарт Дандар Лхарамбын «*Mongγol üsüg-ün yosun-i sayitur nomlaysan Kelen-ü Ćimeg kemegdekü orušiba*» (үзэмүү Балданжапов 1962b., р. 21 – 30) хэмээх хэлний зүй зэргийг дурдаж болно. Энэ дэгийн хэвлэлийг үзээд ар монголчууд “*γa/ge –д цэгтэй судар*” гэгцгээнэ.

1.3. “*Ga-yin doluy-a*” -гийн зарим нь цэгтэй – В. дэг (*га-гийн долоогийн зарим нь цэгтэй*)

“*Ga-yin doluy-a -гийн зарим*” буюу “*γa-yin ayimaγ -ийн зарим*” гэдэг нь *g* (*ge, gi-gō, gü*) үе-үсгүүдийг багтаахгүй, зөвхөн *γ* (*γa, γo, γu*) гурван үеийг тэмдэглэсэн үсгийн нэр болно.

“Өмнө нь хоёр цэгтэй *hēth*” = *γ*. Тодорхой хэлбэл, үе эхлэгч *γ* (*γa, γo, γu*) үсгийн өмнө хоёр цэгтэй, үе төгсгөгч *γ* үсэг цэггүй.

“Цэггүй *hēth*” = *q*. Тодорхой хэлбэл үе эхлэгч *q* (*qa, qo, qu*) цэггүй.

“Цэггүй *kāph*” = *k* ба *g*. Тодорхой хэлбэл үе эхлэгч *k* (*ke, ki, kō, kü*), *g* (*ge, gi, gō, gü*) ба үе төгсгөгч *g* цэггүй.

“Өмнө нь нэг цэгтэй *nün*” = *n*. Тодорхой хэлбэл, үе эхлэгч *n* (*na, ne, ni, no, nu, nō, nü*) үсгийн өмнө нэг цэгтэй, үе төгсгөгч *n* үсэг цэггүй.

“Хойно нь хоёр цэгтэй *šin*” = *š*. Тодорхой хэлбэл, үе эхлэгч *š* (*ša, šo, šu, šō, šü*) үсгийн хойно хоёр цэгтэй, тайлагдал: *i* эгшгийн өмнөх *š* (*ši*) цэггүй.

Сонгодог монгол бичгийн хэлний шинэ үе гэгдэх сүүлийн хоёр зуун жилийн хугацаанд журамшин тогтсон, орчин үеийн буюу одоогийн монгол бичгийн ном зохиол энэ бүлэгт хамаарна.

1. 4. Ялгах тэмдэггүй – Г. дэг (цэггүй)

Дэгийн нэрлэлт: “*čeg ügei üsüg*” (ардын нэрлэлт) = “*temdeg-i oγuruysan*” (*Oγtargui-yin Mañi-1*, p. 13r.), “*qoyar čeg-i orkiju*” (*Todudqayči toli*, p. 58), “*ерөөсөө цэг тавьдаггүй*” (Ц. Шагдарсүрэн, 2001, p. 230).

Ганжуур тэргүүтэн буддын шашны утгазохиолын монгол орчуулгын асар их ном судрын хэвлэл энэ дэгийг баримталжээ. Энэ дэг дотроо а) *жа* –гаас бусад нь ерөөсөө цэггүй; б) хааяа зарим эргэлзээтэй юмуу эндүүрэлт үгэнд⁹ цэгтэй – ийм хоёр үндсэн хувилбартай.

1. 5. Монгол бичгийн Цагаан Толгойн дэс

1.5.0. Тэмдэглэл

Ялгах тэмдэг – дан ба давхар цэгүүдийг би энд галиг үсгийн дор зураас¹⁰ тавьж тэмдэглэв. Үүнд,

\underline{n} = өмнөө нэг цэгтэй *n* үсэг (одоогийн монголын кирил үсэгт “н”)

\bar{q} = өмнөө хоёр цэгтэй эр *q* үсэг - нармайн чанга, хамжих гийгүүлэгч (одоогийн кирил монгол үсэгт “х”)

\underline{k} = өмнөө хоёр цэгтэй эм *k* үсэг – хэлний хойгуурхи чанга, хамжих гийгүүлэгч (одоогийн кирил монгол үсэгт “х”)

\bar{g} = өмнөө хоёр цэгтэй эм *g* үсэг – хэлний хойгуурхи сул, хамжих гийгүүлэгч (одоогийн кирил монгол үсэгт “г”)

$\bar{γ}$ = өмнөө хоёр цэгтэй эр *γ* үсэг – нармайн сул, шүргэх гийгүүлэгч (одоогийн кирил монгол үсэгт “г”)

\bar{p} = *jartiγ* гэдэг тэмдэгтэй *p* үсэг (одоогийн кирил монгол үсэгт “п”)

\underline{d} = хэвтээ *d* үсэг (одоогийн кирил монгол үсэгт “д”)

\underline{t} = босоо *t* үсэг (одоогийн кирил монгол үсэгт “т”)

1.5.1. Сакя¹¹ бандида Гунгажалцаны Цагаан Толгой:

*a, e, i, \underline{n} , b, \bar{q} / \underline{k} , γ /g, m, l, r, s, d, t, y, č, j, w(v)*¹²

1243 онд зохиогдсон энэ Цагаан Толгой уг эхээрээ оллоогүй, 1727 оны орчим *Bstan-‘dzin-grags-pa* (Данзандагва) зохиосон журамласан хэлзүйн зохиолоор уламжлагдан ирсэн (*Oγtargui-yin mañi* – 1: p. 3r.; *Oγtargui-yin mañi* – 2: p. 4v.).

⁹ Эндүүрэлт үгийн (*endegüreltü ner-e*) тухай бандида *Deligjungnai* олон сонин жишээ үзүүлсэн байдаг (*Todudqayči toli*, p. 60-61).

¹⁰ Эртний монгол бичвэрийг галиглахад үсэгзүйн талаас нарийн нягт хандсан мажарын монголч нарын чухал санаачилгын (*Ligeti L.*, 1972, p. 9 – 11) дагуу би энд ялгах тэмдэгтэй юмуу дүрс ялгасан үсгийн дээр доор зураас тавьж тэмдэглэв.

¹¹ *Сакя* = *Сажя/Саж*. Төвөд бичгийн *кya/кя* үеийг монголчууд *ja/жа* болгон уншдаг аж: Шакаямуни = Шагжамуни, Чос-кий-одзер = Чойжи-одсэр, Лджанг-скяа хутугту = Жанжаа хутагт.

¹² Гунгаажалцаны Цагаан Толгойд эртний монгол хэлний уруулын эгшгүүд харагдахгүй байна. Тэдгээрийг энэ *v* (*u*) үсгийн тусламжтайгаар бичих тул нийлмэл бүтэцтэй үсэг гэж үзээд Цагаан Толгойд оруулаагүй бололтой гэдэг. Өөрөөр хэлбэл < *waw=о/и, waw+γod=ö/ü* > гэсэн сонирхолтой дүгнэлт байдаг (Лувсанвандан Ш., 1965, p. 21, Төмөртоого Д., 2002, p. 477).

1.5.2. Богд Чойжи-одсэрийн Цагаан Толгой:

a, e, i, o, u, ö, ü, n, b, p, q/k, γ/g, m, l, r, s, š, d, t, y, č/c, j/z, v, ng

1305 оны орчим зохиогдсон энэ Цагаан Толгой уг эхээрээ олдоогүй, дээр дурдсан Данзандагва-ын зохиолоор уламжлагдан ирэв (*Oytargui-yin mañi* – 1: p. бг.; *Oytargui-yin mañi* – 2: p. 8v – 9r.).

1.5.3. Билигүүндалайн¹³ Цагаан Толгой:

a, e, i, o, u, ö, ü, n, b, γ/g, q/k, m, l, r, s, d, t, y, č, j, v

XVII зууны эхэн хагаст нэрт орчуулагч Bilig-ün Dalai –ийн зохиолуудад байна. Г/Г үсгийг Q/К үсгийн түрүүнд оруулан дэслэжээ. Энэ бол ноцтой өөрчлөлт! (Bilig-ün Dalai, p. 2r.-2v.)

1.5.4. Өвөрмонголын Цагаан Толгой:

a, e, i, o, u, ö, ü, n, b, p, q, k, γ, g, m, l, s, š, t, d, č, j, y, r, v, (f, ž, c, k, h)

Өвөрмонголд гарсан толь бичгүүдийн толгой үгс энэ цагаан толгойн дараалалтай (Luvsandordž 1995, p.19).

1.5.5. Армонголын Цагаан Толгой:

a, e, i, o, u, ö, ü, n, b, q, k, γ, g, j, y, t, d, m, č, r, s, š, l, v, (f, p, ž, c, k, h)

Монгол улст гарсан толь бичгүүдийн толгой үгс энэ цагаан толгойн дараалалтай (Luvsandordž 1995, p.19).

2. Ялгах тэмдгийг журамласан түүх

2. 1. Монгол бичгийн анхны багш нарын таалал ба мэргэдийн их хурал

18-р зууны эхээр өмнөд монголын хэл шинжлэлч эрдэмтэн лам Bstan-‘dzin- grags-pa (Данзандагва) “*Jirüken-ü tolta-yin tayilburi – Üsüg-ün endegürel-ün qarangyui-yi arilyayči Oytaryui-yin Mañi*” гэдэг нэртэй, ном судрын хэлний журамлах хэлзүйн багахан номыг бичиж “бээжин бар” гэдэг нэрээр алдаршсан хэвлэлийн газарт хэвлүүлэн тархаав. Түүний зохиолд журамласан зөв бичихзүй, дуудан унших дүрмүүдийг монгол үсэгзүйн бүх дэг шууд хүлээн авсан. Өнөө үеийг хүртэлхи сонгодог монгол бичгийн хэлний зөв бичих зүй бол тэр судрын журамлал юм. Тэр журмыг Сакяа Бандида Гунгаажалцан үүсгэж (13-р зууны эхэн), Богд Чойжи-одсэр нарийвчлан тогтоосон (14-р зууны эхэн) богдосын журам (boγdas-un jigum) гэж Данзандагва тодорхойлсон юм.

Гэвч харамсалтай нь түүний үсэглэвэр зүйн (цагаан толгойн) журамлалыг (А. дэг) монголчууд бүх нийтээр шууд хүлээн авсангүй. Номын багш, бичгийн сэхээтний дунд маргаан мэтгэлцээн дэгдэж, асуудлыг хэлбичгийн сэхээтний их хурлаар (“*merged quran*”) шийдвэрлэх манж эзэн хааны зарлиг гаргуулахад хүрэв.

Тэр тухай Бандида Дэлэгжунай бичсэн нь: “*qa –yin törül doluyula-yin emün-e, endegürel qayaqu qoyar čig talbiqu keregtei bolbaču, edüge manayar amitu ba amin ügei ya γagčayar-tur talbiju бүкүй-йи, üsüg γaryayсан angqan-u bayси-yin tayalal-dur ülü neyičekü bolai kemen Jirüken-ü Tolta-yin tayilburi-dur qayaju amui.*

Teγimü bolbaču Nayiraltu Töb ejen-ü üy-e-dür jarliγ-iyar olan merged quran, degedü lJang-Kiy-a boγda-yin hum jarlig-i mongγolčilaju γaryaqui-dur sigümjilen ariγudqaysan keb-ün üsüg-i sinjilebesü bičiküi-dü

¹³ Билигүүндалай < Bilig-ün Dalai, XVIII зууны үеийн (төвөд-монгол) нэрт орчуулагч (2.2.5. үз).

könggedken, nöbür-iyer medekü olangkin-a orkiju, endegüreltü ner-e -dü talbişan üjegdemiü. qalaqun, yalaqun (үз дагалт-4) *kemekü qoyar-un angqan küiten-ü qarsi qani-yin ner-e, qoyaduyar sibayun-u ilyal-un ner-e-dür medekü-dü, nöbür-ün kücün be temdeg keregtei metü jisigdekü bolai*” (Todudqayçi toli, 1927, p. 58).

Энд хэлсэн “эзний зарлигаар олон мэргэд хуран, шүүмжлэн ариутгасан хэвийн үсэг” (*ejen-ü... jarliy-iyar olan merged quran... sigümjilen ariyudqaysan keb-ün üsüg*) гэдэг үгс бол “эзэн хаан зарлиг буулгаж, эрдэмтэн мэргэдийн хурлыг зохион байгуулж шүүмжлүүлэн хэлэлцүүлээд хуульчлан баталсан хэвлэлийн үсэг”¹⁴ (цаашид *keb-ün üsüg* гэгэ) гэсэн ноцтой тодорхойлолт байна.

Keb-ün üsüg гэдэг бол өмнө дурдсан ялгах тэмдэггүй үсэгийг (Г. дэг) монгол номын хэлний баталгаат үсэг болгон тогтоож, номын хэлний сонгодоогоос өмнөх үед нэгэнт тогтсон уламжлалыг эвдэлгүй үргэлжлүүлэх гэсэн “мэргэдийн” олонхийн санал байжээ. Тэгэхдээ ялгах тэмдэгт үсгийн системийг огт анхааралгүй орхисон биш, буруу уншин утга эндүүрч болмоор зарим тохиолд (*endegüreltü ner-e dü*) ялгах тэмдгийг тавьж болно гэж шийдвэрлэсэн нь Дэлэгжунайн зохиолоос мэдэгдэх аж. Энэ шийдвэр бас шинэ юм биш, сонгодоогоос өмнөх үеийн монгол ном сударт байсан уламжлал юм.

2. 2. “Үсгийн эндүүрлийн харанхуй” (*Üsüg-ün endegürel-ün qaranguyi*)

Данзандагвын зохиолын бүтэн нэр нь “*Jirüken-ü tolta¹⁵-yin tayilburi – Üsüg-ün endegürel-ün qaranguyi-yi arilyayüci Oytaguyi-yin Mañi*”¹⁶. Судлагч нарын ихэнх нь энэ нэрийн эхний хэсэг “*Jirüken-ü tolta-yin tayilburi*” гэсэн холбоо үгээр бүтэн нэрийг товчлон орлуулдаг, зарим нь сүүлчийн хэсэг “*Oytaguyi-yin Mañi*” гэсэн холбоо үгээр товчлон орлуулан нэрлэж ирэв.

¹⁴ Зарлиг гаргагч манж эзэн хаан Юн-Чжен 1723 – 1735 онд хаанчилсан болохоор тэр их хурал болж *Keb-ün üsüg* баталсан үе бол түүний үе болно. Данзандагва, Билигүүндалай хоёрын үсгийн ялгах тэмдэг журамласан зохиолууд бас энэ үеийнх байна. Тийм болохоор энэ хоёр эрдэмтний санал, тэр их хуралаас дэмжлэг олсонгүй нь энэ баримтаас мэдэгдэнэ.

¹⁵ *Jirüken-ü tolta* (халх. *зүрхний толт*) гэдэг нь гол судас ба зүрх хоёрын уулзварын нэр, ойролцоо холбоо үг нь голт зүрх, зүрхний уг. Метафор утга нь “амин гол, сүнэс, зүрхний зүрх, үндсийн үндэс,” гэсэн маш дээдлэх санаатай хэлц үг юм. *Jirüken-ü tolta* гэдэг нэр бол монголын номын хэлний талаар тогтоосон *boydas-un jirum* гэсэн санаатай. *Tolta* гэдэг үгийн эртний утга мартагдсан тул одоогийн хэлний *tolu / толь* ‘mirgor’ гэдэг үгтэй тааварлан холбож *Зүрхний тольт* гэж нэрлэх явдал гарч, тэрнийг монгол бичгээр *Jirüken-ü tolita / tolitu* гэж бичиж хэвлэснийг би ардын этимологийн эндүүрэл гэж үзнэ. Энэ үгийн тухай зөв зүйтэй тайлбарыг (Шагдарсүрэн, 2007, 161-р талд) үзэмүү.

Jirüken-ü tolta гэдэг нэрийг орос хэлээр “сердечный покров” (*Jirüken* ‘сердце’, *tolta* ‘покров’) гэж (Пагва 1957, дотор хавтасандхи нэр) орчуулсныг Балданжапов шүүмжлээд дэлгэрэнгүй тайлбар өгсөн нь: “перевод представляется нам менее удачным, чем ранее известные переводы *Jirüken-ü tolta* как “артерия сердца” (Б. Лауфер, Очерк монгольской литературы, Л., 1927, стр.49) или “сердечная аорта”. На наш взгляд, слово *tolta* вообще не употребляется в значении “покров”, нам кажется, что перевод “сердечная аорта” точнее и не требует пересмотра (Балданжапов 1962, p. 31). Оно (*Jirüken-ü tolta*) получило широкое распространение именно как название грамматического сочинения. При этом давно известно и бесспорно следующее: Во-первых, название *Jirüken-ü tolta* является традиционным и связано своим происхождением с восточной традицией, согласно которой книгам давалось образные и иносказательные названия. Во-вторых, под выражением *Jirüken-ü tolta* имеется в виду то главное и сжатое, которое стало основой грамматического учения о монгольском языке. На эту мысль наводит то, что в самом сочинении *Jirüken-ü tolta-yin tayilburi* сказано: *Jirüken-ü tolta mongyol üsüg-ün bodatu yolul endegürel ügei mön* – “*Jirüken-ü tolta* является подлинной и безошибочной основой монгольского письма”. Отсюда нам представляется возможным сделать смысловый перевод выражения *Jirüken-ü tolta* как “сухая основа”, или “подлинная основа”, а *Jirüken-ü tolta-yin tayilburi* как “комментарий [сочинения] “Сушей основы” (Балданжапов 1962, p. 32).

¹⁶ *Oytaguyi-yin Mañi* ‘огторгуйн эрдэнэ’ гэдэг нь Тэнгэрийн нар. Зохиолыг ингэж нэрлэх нь буддист уламжлал юм. Буруу ойлгох, эндүүрлийн төөрөгдлийн харанхуйд гэрэл тусгасан ном гэсэн бэлгэдэл утгатай. *Öcükен üsüg nomuyadqaly-a-yin jirüken-ü qaranguyi-yi arilyan ayiladuyci mingyan naran-u gerel kemekü oruşıba* (Сазыкин А. С., 1998, p. 264) гэсэн нэртэй ном ч байдаг.

Уг нэрний нь дунд хэсэгт байгаа *Üsüg-ün endegürel-ün qaranguyi-yi arilyayçi* гэсэн чимэлгэ-тодотголыг судлагч нар анхаардаггүй. Гэтэл энэхэн хэллэгт, Бурханы үнэнч шавь – монгол эрдэмтэн ламын үзэл баримтлал, бурхны номыг эндүү ташаагүйгээр сүсэгтэн түмний сэтгэлд хүргэх зөв арга замыг заагаад “олонхийн саналын” дарамтад орсон монгол бичгийн багштаны гуниалт бодол шингэснийг олж мэдэх тийм төвөгтэй биш.

Түүний бодлыг сэргээвэл: “Бурханы номыг монгол хэлээр орчуулан хэвлэх ажил өрнөж байна. Үүн шиг сайхан юм хаана байхав. Гэвч монгол үсэгт эндүүрэл их байгаа болохоор бурханы номыг эндүү буруу унших бичих явдал их байна. Энэ бол том нүгэл. Монгол үсэгтхи эндүүрлийг арилгах хэрэгтэй. Үсгийн эндүүрлийн харанхуйг арилгах хэцүү биш. Монгол үсгийн анхны богд багш нарын журамласан ялгах тэмдэгтэй цагаан толгойг л хуульчлан баталчих. Тэгээд л боллоо!”

2. 2. 1. Бандида Гунгаа –одсэрийн шинэ *Jirüken-ü tolta* – ийг шүүмжилсэн нь

Эндүүрлийн харанхуй гэдэг бол монгол хэлэнд хатуу хэллэг. Ийм хатуу үгээр юу хэлсэн бэ? гэсэн асуулт тавигдахгүй гэж үү? Энэ асуултад хариулсан бичвэр, Данзандагвын зохиолд бий юм:

“*Basa Bañdita Gun-dka*’-’*od-zer –ün Jirüken-ü Tolta-dur na –yin törül-ün temdeg kiged qa –yin törül-ün temdeg-i oyuruγad ya –dur temdeg talbiγad, ya –yin busu törül-dür temdeg ügei böged; teyimü-yin tula jarim bičigsed-tür – qa dur temdeg kiged, jarim-dur ya –dur temdeg talbiγsan eldeb bayinam. Teyin atala Čos-kyi-’od-zer- ün jokiyaysan Jirüken-ü Tolta anu Mongyol Üsüg-ün bodatu youl endegürel ügei mön-ü tula Boydas-un jirum-i dayabasu merged-tür ülü sonjydamui :.*” (Оутаруй-ийн Маһи 1, р. 12v.- 13r., Оутаруй-ийн Маһи 2, р. 19r. – 19v.) Дагалт –5 үзэмүү.

Энэ бичвэртхи:

na –*yin törül* гэдэг бол *na, ne, ni, no, nu, nö, nü* – эдгээр 7 үе,

qa –*yin törül* гэдэг бол *qa, ke, ki, qo, qu, kö, kü* – эдгээр 7 үе,

ya –dur temdeg talbiγad гэдэг бол *ya, yo, yu* – энэ гурван үе үсэг,

ya –yin busu törül гэдэг бол *ge, gi, gö, gü* – эдгээр 4 үе үсгийг зааж байна.

Тэгэхлээр *Bañdita Gun-dka*’-’*od-zer –ün Jirüken-ü Tolta* (бандида Гунгаа-одсэрийн Зүрхний Толт) гэдэг зохиолын цагаан толгой бол монгол бичгийн В. дэг бөгөөд одоогийн монгол бичиг (Гунгаа-одсэрийн огоорсон “*na*” үсгийн цэг яваандаа сэргэсэн бололтой) мөн ажээ. Эрдэмтэн Гунгаа-одсэрийн зохиолдхи ялгах тэмдгийн хэрэглээг Данзандагва үсгийн эндүүрэлд тооцсон нь дээр эш татсан бичвэрийн *Teyin atala Čos-kyi-’od-zer – ün jokiyaysan Jirüken-ü Tolta anu Mongyol Üsüg-ün bodatu youl endegürel ügei mön-ü tula Boydas-un jirum-i dayabasu merged-tür ülü sonjydamui* гэсэн өгүүлбэрээс мэдэгдэж байгаа юм. *Boydas-un jirum-i dayabasu merged-tür ülü sonjydamui* гэсэн сүүлчийн хэсэг бол бандида Гунгаа-одсэрт хандсан үг байна. Богдос (*Boydas*) гэдэг нь монгол бичгийн анхны багш нар: Сакя бандида Гунгааажалцан, Богд Чойжи-одсэр хоёрыг зааж байна.

Түүнээс гадна Данзандагва, “*Mongyol-un jayun qorin yurban üsüg bui bögetele ... Bañdita Kundg’a-’od-zer šine Jirüken-ü Tolta γaryaju Čhos-kyi-’od-zer-ün jokiyaysan jayun nayman üsüg kemegsen bölüge. ... Mongyol nom-dur edeger güičekü kemen sedkigsen bayinam. Teyin atala Čos-kyi-’od-zer-ün γaryaysan ša –yin törü kiged pa –yin törül qoyar-ača jurγuyad jurγuyad orkiγsan bolai. Edüged-tür erče bičigsen sudur-tur edeger üsüg ügei bolγsan šiltayan anu tere metü bolai.*”

(Оуҗарҗуй-йин Мағи 1, р. 11v., Оуҗарҗуй-йин Мағи 2, р. 17r.-17v.) (“Монголын 123 үсэг буй бөгөөтөл ... бандида Гунгаа-одсэр шинэ Зүрхний Толт гаргаж, “Чойжи-одсэрийн зохиосон 108 үсэг” хэмээсэн бөлгөө... Монгол номд эдгээр гүйцэх хэмээн сэтгэсэн байнам. Тийн атал Чойжи- одсэрийн гаргасан *ᠶа* – гийн төрөл хийгээд *pa* –гийн төрөл хоёроос зургаад зургаадыг орхисон болой. Өдгөөдөд эрт бичсэн сударт эдгээр үсэг үгүй болсон шалтгаан тэр мэт болой”) гэж түүнийг шүүмжлээд эцэст нь “*Jöb nom delgereküi-dür buruyu nom qouslaqu jima yosun metü bölüge kemegsen metü buyu uu. esebesü šimnus qudqulaysan bolai.*” (Оуҗарҗуй-йин Мағи 1, р. 12v., Оуҗарҗуй-йин Мағи 2, р.19r.) (“зөв ном дэлгэрэхүүд буруу ном хослох жам ёс мэт бөлгөө хэмээсэн мэт буюу уу; эсвээс шумнас хутхалсан болой”) гэсэн бий.

Данзандагва зохиолынхоо төгсгөл хэсэгт “*Yosuyar bičigsen-ü aci tusa kiged buruyu bičigsen-ü gem eregüü*” (Оуҗарҗуй-йин Мағи 1, р. 13r., Оуҗарҗуй-йин Мағи 2, р. 19v.) (“Ёсоор бичсэний ач тус хийгээд буруу бичсэний гэм эрүү”) гэсэн нэртэй тусгай бүлэг хийж, үсгийн эндүүрлийн харанхуйгаас шалтгаантай нүгэлийн аюулыг тодорхойлов. Энэ хэсэг бол битүүдээ “бандида Гунгаа-одсэрийн эндүүрэлт цагаан толгой, түүнчилэн дээр дурдсан эзэн хааны *keb-ün üsüg* бол номыг тэвчих нүгэлийн үндэс байна” гэсэн санааг уншигчид төрүүлэхээр бичигджээ. Тэнд “Зальхай эндүү, буруу бусцар унших, бичих”¹⁷ явдлыг “дээдийн номыг тэвчсэн” нүгэлд тооцоод (*jaliqai endegüü buruyu busuĉar ungsibasü bičibesü degedü nom-i tebčigsen bölüge* – Оуҗарҗуй-йин Мағи 1, р. 13v.) “мэргэн, тэнэг бүгдээр номыг тэвчих үйлсийг цээрлэх”-ийг сануулж (*mergen teneg bügüde-ber nom-i tebčikü üiles-i čegerlebesü* – Оуҗарҗуй-йин Мағи 1, р. 13r.), “... Ганга мөрний хумхийн тоот Архадыг алснаас судрын аймгийг тэвчсэний нүгэл асар үлэмж” (*Alin-iyar Gangga mören-ü qumaki-yin toyatan Arahad-i alaysan-aĉa ber, alin-iyar Sudur-un ayimay-i tebčin üiledügsen nigül ene inü asuru ülemji* – Оуҗарҗуй-йин Мағи 1, р. 14r.) гэсэн номлолыг “*Sa-madi-yin qayan*” (Оуҗарҗуй-йин Мағи 1, р. 14r.) судраас эш татах зэргээр эрс хурц хэллэгээр бичсэн нь анхаарлыг татна. Бичиг үсгийн тухай жижигхэн номд “номыг тэвчихийн нүгэлийн” тухай яагаад тийм дэлгэрэнгүй тодорхойлов? гэдэг бол асуулт юм.

2.2.1.2. Данзандагва *Оуҗарҗуй-йин Мағи* хэмээх зохиолдоо гарсан *Mongyol-un jayun qorin yurban üsüg* (Монголын 123 үсэг) гэгчийг ангилан үзүүлсэн нь:

Тайлбар: Доорхи хүснэгтэдхи хаалтны гадна байгаа үсгүүд бол Данзандагвын үгээр: Сакяа бандида-ын зохиосон *ijayur-un döčün dörben üsüg* гэдэг нь юм.

Хаалтад байгаа үсгүүд бол Данзандагвын үгээр: Чойжи-одсэрийн гаргасан ба нэмж зохиосон үсгүүд гэдэг нь юм. Ингээд үе-үсэг 121, нийлмэл үсэг 1(ng), нөхцөл 1(iyar/iyer), бүгд 123 тэмдэгт ажээ.

Эртний монголын хэлзүйч нарын домогч баримтлалын дагуу бол Чойжи-одсэр 14 čingy-a (*a – ja хүртэлхи*) үсэг тус бүрээс 2 шинэ үсэг (хаалтад байгаа нь), 14 köndeï (*e – je хүртэлхи*)

¹⁷ эндүү буруу унших бичих явдал Үүний жишээнд олныг хэлж болох боловч би энд Данзандагвын энэ зохиолд гарсан зөвхөн хоёр үгэн дээр үзүүлмээр байна. Уг эхэд цэгтэй *q* үсгээр эхэлсэн хоёр үг – үйл үг: *qabiya-* (холбо-/холбогдо-) , нэр үг: *qabiy-a* (холбоо/холбогдол) гэсэн нэг үндэст үгс бий. Энэ үгсийн эртний утга одоо их мартагдсан юм. Тийм болохоор эхний үйл үгийг таамгаар уншиж кирилжин монголоор “хуваа-” (разделить) гэсэн өөр үг болгож (үз Пагва Т., 1957, р. 44), орос хэлээр “*буквы образования которых не аналогично*” гэж бүрхэг орчуулав (үз Балданжапов П. Ц., 1962, р. 69). Нөгөө нэр үгийг, хоёр цэгтэй *q* үсгийг *у* үсгээр уншдаг дэгийн дагуу “*гавьяа*” (заслуга) гэсэн үгс болгож (үз Пагва Т., 1957 р.50), орос хэлээр “*слава*” гэж орчуулав (үз Балданжапов П. Ц., 1962, р. 80). Тэр хоёр үгийн утгыг англи хэлээр аятайхан гаргасныг (Lessing 1960, р. 897) үзэж ажиамуу.

үсэг тус бүрээс бас 2 шинэ үсэг (хаалтад байгаа нь), бүгд 56 үсэг гарган авч *ijayur-un döc'in dörben* дээр нэмээд нийт 100 үсэг болгосон гэх (Энэ тухайд Данзандагва Билигүүндалай хоёрын үзэлт адил). Адил бус үзэлт юу вэ гэвэл,

а) Данзандагва-ын үзэлт:

Чойжи-одсэр 100 үсэг дээрээ доорхи шинэчлэл нэмсэн нь:

- 1) *ba* үсэгт дээр нь хоёр чих мэгийг бичээд *pa* үсэгийг хийсэн,
- 2) *sa* үсэгийн гээгэнд хоёр цэг тавиад *ša* үсэгийг хийсэн,
- 3) залган бичихэд (үгийн дунд байрлалд) *ja* үсэгийг *ča* мэт бичээд *ja* үсэг мэт дуудах шинэчлэл хийсэн. Ингээд тэр гурван үсэг тус бүрийг 7 эгшигээр (*a, e, i, o, u, ö, ü*) хувилган бичиж 21 үсэг болгоод *ng, iyar* хоёртой хамт 23 шинэ үсэг болгож бүгд 123 үсэгтэй болсон гэх.

б) Билигүүндалайн үзэлт:

1) Чойжи-одсэр 100 үсэг дээрээ *ša, pa* хоёр үсэгийг нэмж 102 үсэг болгосон. Тэгээд дээр нь дундхи байрлалын *ja, ji, jo, ju, jö, jü* үсгүүдийг нэмж бүгд 108 үсэг болгосон.

2) Хожим нь Гүнгаа-одсэр тэр 108 үсэгийн дээр

- *ša, ši, šo, šu, šö, šü* (*sa üsüg-ün gejigen-dür qoyar čeg talbiysan ša*)
- *pa, pi, po, pu, pö, pü* (*ba üsüg-ün deger-e morin-u čikin metü temdeg talbiysan pa*)
- *iyar, ja* (дундхи байрлалын), *ng* үсгүүдийг нэмж бүгд 123 үсэг болгосон гэх (Билигүүндалайн тооцоололд *pa, ša, ja* гурван чанга үсэг, Чойжи-одсэрийнхтэй давхардсан нь гайхалтай).

čingy-a	köndei	sayarmaγ	kijayar-taki qoyar	basa
a (o u)	e (ö ü)	i	va	(ng)
na (no nu)	ne (nö nü)	ni	ve	(iyar)
ba (bo bu)	be (bö bü)	bi	----	
qa (qo qu)	ke (kö kü)	ki		
γa (γo γu)	ge (gö gü)	gi		
ma (mo mu)	me (mö mü)	mi		
la (lo lu)	le (lö lü)	li		
ra (ro ru)	re (rö rü)	ri		
sa (so su)	se (sö sü)	si		
da (do du)	de (dö dü)	di		
ta (to tu)	te (tö tü)	ti		
ya (yo yu)	ye (yö yü)	yi		
ča (čo ču)	če (čö čü)	či		
ja (jo ju)*	je (jö jü)*	ji*		
-----	-----	----		
(pa po pu)	(pe pö pü)	(pi)		
(ša šo šu)	(še šö šü)	(ši)		
(ja jo ju)**	(je jö jü)**	(ji)**		
51	51	17	2	2

* Эхэндхи байрлалын *j* үсэг (*silbi*)

** Дундхи байрлалын *j* үсэг (*moquyu eber, moquyu öncüg*)

2. 2. 2. Т. Пагва-гийн эндүүрэл ба залруулга

Данзандагвын энэ алдарт зохиолын анхны сайн судалгааг Монголын хэл шинжлэлч Т.Пагва хийв. Тэр, уг номын агуулгыг танилцуулаад “Монгол хэлний үгсийн утгыг ялгахад хэрэглэгдэх гол бүх авиануудыг илэрхийлэн чадсан тийм үгсийн системийг Чойжи-одсэр өөрийн реформоор үнэхээр гаргаж чадсан” (Пагва 1957, р 13), “... монгол хэлний зүйн өвөрмөц онцлогийг туйлын нарийн шинжлэн дүгнэсэн болох нь гайхамшигтай” (Т. Пагва, 1957, р. 14) гэж өндөр үнэлсэн дэлгэрэнгүй судалгааны хамт, уг зохиолын монгол бичгийн хуулбар¹⁸, кирил монголжин хөрвүүлэг, олон үг нэр томъёоны тайлбартайгаар товхимол болгон хэвлүүлсэн юм.

Нэг харамсалтай юм болсон нь гэвэл, Т. Пагва, Данзандагвын зохиолдхи хоёр цэгтэй \bar{q}/k үсгийг γ/g үсгээр, цэггүй γ/g үсгийг q/k үсгээр эндүүрэн уншиж кирил үсгээр буулгав (монгол үсгийн В. дэгийн сурагчийн учир буй заа). Ингээд түүний кирилжин монгол хөрвүүлэгт “Бас бандид Гунгаа-одсэрийн Зүрхний тольтод НА-гийн төрлийн тэмдэг хийгээд ГА-гийн тэмдгийг огоороод, ХА-д тэмдэг тавиад, ХА-гийн бус төрөлд тэмдэг үгүй...” (Пагва Т., 1957, р. 50) гэх зэргийн эндүү ташаа бичвэр, түүний кирил-монгол хөрвүүлэгт гарсны улмаас q/k үсэгт цэгтэй ном судрыг бандида Гунгаа-одсэрийн дэгийнх гэж үздэг эндүүрэл, монгол хэлний багш, сэхээтний дотор газар авсан билээ. Т. Пагва багштан тэр эндүүрлээ¹⁹ арай хожимдож мэдсэн юм. Түүний судалгааны ном нэгэнт хэвлэхэд бэлэн болж “боолтод” орсон²⁰ хойно мэдсэн учир “залруулга” (үз дагалт-6) хэмээгдэх хуудасхан цаас хавчуулахаас өөр аргагүй болсон юм. Гэвч номын залруулгыг хэн унших вэ дээ!

2. 2. 3. П. Б. Балданжаповын эндүүрэл

Данзандагвын зохиолын тухай гадаадын эрдэмтний анхны томоохон судалгаа орос хэлээр гарсан (Балданжапов 1962) юм. Бусад олон орны эрдэмтэн судлагч нар уг зохиолын нэрийг дурдаж, монгол хэл бичгийн эрхэм чухал дурсгал мөн гэсэн үнэлэлт өгсөн болон уг зохиолдхи түүхийн сонирхолтой тэмдэглэлийн хэсгийг орчуулсан, хэлзүйн зарим нэр томъёог монгол-гадаад хэлний толь бичигтээ хэрэглэсэн төдийгөөс хэтрэхгүй бөгөөд одоо хүртэл оросоос өөр хэлэнд орчуулагдсангүй.

Орос улсын буриад эрдэмтэн Балданжаповын энэ зохиол, судалгааны дэлгэрэнгүй удиртгал, монгол эх бичвэр (Буриадын Агийн Дацангийн модон хэвийн хэвлэлийн гэрэл зургийн хувь),

¹⁸ Т. Пагва-ийн номд орсон *Jirüken-ü tolta-yin tayilburi* –ийн монгол бичгийн хуулбар бол ялгах тэмдгийн хувьд цагаан толгойн дэгүүдийг холилдуулсан, ялгах цэгүүдийг тохиолдлын чанартай, дураараа тавьсан (Владимирцов Б. Я., 1989, р. 76) мэт харагдах базаахгүй эхийн хувилбар юм. Позднеевийн “унших бичигт” хэвлэгдсэн тэр базаахгүй (Балданжаповынхоор не может считаться образцовым) хувилбар нь Т. Пагва –ийн номд хуулагджээ (Балданжапов П. Б., 1982, р. 18, р. 20). Д. Чойжалсүрэнгийн “унших бичигт” (*Сoyijalsürüng D.*, р. 246 – 266) хэвлэгдсэн хувилбар бас тэр Позднеевийнх бололтой. Жич, Чойжалсүрэнгийн хэвлэлд (р.263) үсгийн махбодын тухай бөлөгт нэгэн тал хуудас орчим бичвэр, хуулан машиндагчийн эндүүрлээр хаягдсаныг тэмдэглэе.

¹⁹ Чойжи-одсэр, Данзандагва нарын цагаан толгойг латин үсгээр галиглан бичиж нийтлүүлсэн ажлууд сүүлийн үед Монголд хэд гарсанд Т. Пагвагийн эндүүрлийг давтсаныг тэмдэглэе.

²⁰ *Боолтод оро* – хэвлэлийн техник ажлын нэр томъёо. Мо. *боолт* < орос. *болт* < англи. *bolt*. Жич, *боолт* гэдэг үгийг одоогийн монголчууд өөрийн хэлний *боо*-/завязывать, *боолт* “повязка” гэдэг-үгээр ойлгодог. Гадаад үгсийг тэгж өөрийн хэлнийх болгон тайлбарлах ардын аргын (Folk-etymological interpretation) тухай дэлгэрүүлэн үзэхийг хүсвэл (Luvsandorj J., 2005, р. 99 – 101) үзэж болно.

орос орчуулга, дэлгэрэнгүй тайлбар, олон хуудас хавсралт (уг зохиолын хураангуй хувь болсон хоёр багахан судрын гэрэл зургийн хувь, уг зохиолдхи нэр томьёонууд ба, хэлзүйн нөхцөлүүд, сул үгсийн жагсаалт, ном зүй гэх мэт) олон юмыг багтаасан нарийн сайн хийсэн ажил юм. Судлагч нар, түүний энэ бүтээлээс монгол хэл бичгийн дурсгалуудын талаар олон чухал мэдлэг, мэдээлэлийг авч болно.

Гэвч бас харамсалтай нь нөгөө хоёр цэгтэй \bar{q}/k үсгийг \acute{g}/g үсгээр, цэггүй y/g үсгийг x/k үсгээр уншиж галигласан (үз дагалт-7А, 7Б.) нь Т. Пагва –гийн эндүүрлийг давтжээ (Балданжапов П. Б., 1962, р. 69).

2. 2. 4. Үсгийн “эндүүрлийн харанхуйд” гэрэл тусгасан нь

2. 2. 4. 1. Агийн Дацангийн²¹ эндүүрэлгүй

Данзандагвын зохиолын уг эхийг хадгалан уламжилсан ном гэвэл одоогоор хоёр хэвлэлийг дурдаж болно. 1) Бээжин барын хэвлэл (*Oyᠲaryui-yin Mañi* 1), 2) Агийн Дацангийн хэвлэл (*Oyᠲaryui-yin Mañi* 2) – энэ хоёр байна.

Энэ хоёр хэвлэл хоёул ялгах тэмдгийг \bar{q}/k үсэгт тууштай тавьж (үз дагалт-1, А дэг), $\underline{d}, \underline{t}$ хоёр үсгийг дүрсээр тууштай ялгасан юм (үз дагалт-8). Балданжаповын хэвлүүлсэн *Oyᠲaryui-yin Mañi* –ийн гэрэл зургийн хувь бол (**Буриадын Агийн Дацангийн хэвлэл**) уг судрын бээжин барын хэвлэлийн хуулбар мөртлөө тун тод хэвлэгдсэн, үсгийн гоё сайхан нь бээжин барынхаас илүү сайнаар барахгүй, монгол цагаан толгойн үсгүүдийн хажууд төвд үсэг (бээжин хэвийн сударт үгүй) хадсан нь (үз дагалт-7В) үсгийн эндүүрлээс бүрэн хагацах арга замыг үзүүлсэн нь түүний чухал онцлог байна. Зарим жишээ:

Мо. хоёр цэгтэй \bar{q}/k үсгийн хажууд тө. «амны» ха үсэг,

Мо. цэггүй y, g үсгийн дэргэд тө. «хагархай» га үсэг,

Мо. хэвтээ \underline{d} үсгийн хажууд тө. «бөгтөр» да үсэг,

Мо. босоо \underline{t} үсгийн дэргэд тө. «бүстэй» та үсэг,

Мо. \check{c} үсгийн дэргэд тө. «хоёр гэдэст» ца (*ts*) үсэг,

Мо. j үсгийн дэргэд тө. «ходоодон» за (*dz*) үсэг хадаж үзүүлэв. Ингэж дурайтал үзүүлсэн байхад судлагч, эндүүрэн уншсан нь олон жил дадсан цагаан толгойн дэг гэдэг хүчтэй ажээ!

Агийн Дацангийн хэвлэлд «мо. \check{c} үсгийн дэргэд тө. «хоёр гэдэст» ца (*ts*) үсэг, мо. j үсгийн дэргэд тө. «ходоодон» за (*dz*) үсэг хадсан» явдал сонин байна. Яагаад гэвэл \check{c} үсгийг халх ба ойрод аялгуутан ца (*ts*) гэж нэрлэдэг (өвөрлөгч аялгуутан ча /*tš*), нөгөө j үсгийг халх, ойрдод за (*dz*) үсэг гэж нэрлэдэг (өвөрлөгчид жса /*dž*). Тэгэхлээр Агийн Дацангийн анхны хэвлэлийн редактор нь ца-лагч аялгуутан байжээ (ойрод Данзандагва²² өөрөө байсан байж магадгүй) гэх бодол төрөгдүүлнэ.

²¹ Агийн Дацан Буриад нутагт (Орос улсын Чита муж гэдэг асан) байсан ламын шашны хийдийн нэр. Модон барын сайн хэвлэлтэй байсан. Модон барыг заавал тэндээ сийлэх албагүй, бусад нутагт хадгалагдан буй сайн хэвийг (модон барыг) зээлж аваачаад хэвлэх арга бас буриад нутагт дэлгэрсэн байсан юм.

²² Данзандагва –ыг ойрад хүн байсан тухай мэдээлэл байдаг (Гомбожав С., 2005, р. 45). Өмнөд монголд жишээ нь Алашаа нутагт ойрад гарлын монголчууд суудаг. “Өмнөт монголын соёл, бусад монголчуудад, бүүр Байгалийн чанадхи нутагт [Буриад] тодорхой нөлөө өгсөн” (Kara D., 1972, р. 39)

2. 2. 4. 2. Ц. Дамдинсүрэнгийн эндүүрэлгүй

Данзандагвын зохиолын талаар уншигчдад эндүүрэлгүй ойлголт өгөх анхны ноцтой санаануудыг академич Ц. Дамдинсүрэн өгсөн билээ. Тэрвээр, 1957 онд нийтлүүлсэн монголын уран зохиолын судлалын бүтээлдээ «Чойжи-одсэрийн зүрхний тольт» гэсэн гарчиг бүхий хоёр хуудас бичвэр өгөв. Түүний цохон тэмдэглэснээс (Дамдинсүрэн Ц., 1957, р. 112–113):

“Чойжи-одсэр монгол үсгийг чанга, хөндий саармаг гурван анги болгон хуваажээ. Ингэж гурван анги болгон хуваасан нь монгол хэлний өмөрмөц байдалд тохирсон бөгөөд, монгол хэлийг судалж байж энэ хувиарыг хийсэн байх ёстой. Энэ хуваарийг хятад, түвд, санскритаас уламжлан авах нөхцөлгүй юм. Учир нь тэр хэлнүүдэд монгол хэлтэй яг адил тийм ялгавар байдаггүй, харин уйгур хэлэнд ийм ялгавар бий юм” (р. 112).

“Монголын хуучин бичгийн дүрмийг үзэхэд нарийн нягт боловсруулсан нь илт мэдэгдэж байна” (р. 112). “... монголын үсгийн дүрмийг XIII зуунаас их урьд эрдэм шинжилгээний суурьтай, нарийн нягт боловсруулсан юм. Үүнийг тэмдэглэж бичсэн нь Чойжи-одсэрийн гавьяа болно” (р. 113).

“Чойжи-одсэрийн зүрхний тольт, долоон зуу шахам жилийн турш монгол бичиг үсгийн гол мөрдлөг болж ирсэн бөгөөд хэл бичгийн эрдэмтэн нарт их нөлөөг үзүүлсээр иржээ. Сажа Бандидын зүрхний тольт зөвхөн цагаан толгой байсан учир, Чойжи-одсэрийн зүрхний тольт бол монголын анхны үсгийн дүрэм, хэлний зүйн зохиол мөн болно” (р. 114). Ц. Дамдинсүрэнгийн эдгээр дүгнэлтүүд бол одоо ч үнэ цэнэтэй хэвээр байна.

Сажа бандида, Чойжи-одсэр, Данзандагва нарын монгол бичгийн цагаан толгойг уг ёсоор нь зөв уншиж, эрдэм шинжилгээний латин үсгээр яаж галиглахыг кирилжин монгол үсгийн жишээн дээр тэр үзүүлсэн юм. Түүний бичиж үзүүлсэн нь: «Сажа Бандид монгол үсгийг шинээр зохиосон биш, зөвхөн цагаан толгой буюу үсэглэлийг зохиосон бололтой, энэ нь: *«а, на, ба, ха, га, ма, ла, ра, са, да, та, за, ца, я, ва/вэ»*²³ гэж бичиж үзүүлэв (Дамдинсүрэн Ц., 1957, р. 112)

2. 4. 3. Ш. Лувсанванданы эндүүрэлгүй

Данзандагвын зохиолыг орчин үеийн, тэгэхдээ нэн шинэ үеийн хэл шинжлэлийн өндөрлөгөөс нарийн судалгаа дүгнэлт хийсэн нь академич Лувсанванданы “эртний монгол хэлний фонемийн систем” гэдэг өгүүлэл чухал болно. Тэр, монгол бичгийн богдосын Цагаан Толгойдхи цэгтэй *hēth / kāph* –ийг *q, k* үсгээр, цэггүй *hēth / kāph* –ийг *γ, g* үсгээр галигласан төдийгүй, монгол хэлний авиануудыг *er-e, em-e, ersü* буюу *cingγ-a, köndei, sayarmaγ* гэсэн ангилалыг судалсан дэлхийн олон монголч нарын сүүлийн 200 жилийн хугацааны үзэл баримтлалыг харьцуулан судлаад тэдгээрийн аль нь ч чухам үнэнийг олоогүй гэж үзээд өөрийн тодорхойлолтыг гаргав. Түүний бичсэн нь (Лувсанвандан Ш., 1965):

²³ Ц. Дамдинсүрэн энэ номоо 1957 оны 5 дугаар сард хэвлэлд шилжүүлсэн үед Т. Пагва, Сажа Бандидагийн тэр цагаан толгойг «а, э, и, на, ба, га, ха, ма, ла, ра, са, да, та, жа, ча, я, ва/вэ» гэж (ха га үсгийг сольж) галиглан (Пагва Т., 1957, р. 41) үзүүлсэн номоо 1957 оны 6 дугаар сард хэвлэлд шилжүүлсэн байх юм. Ц. Дамдинсүрэн багштаны тэр номын хоёр дахь хэвлэлд Сажа Бандидын дээрх цагаан толгойг «а, б, х, г, м, л, р, с, д, т, з, ц, я, н – эдгээр арван дөрвөн толгой үсэг» гэж дэсийг өөрчлөн (үз Дамдинсүрэн 1999, р. 149) бичив. Бас анхны хэвлэлд «... дээр нь *ng ай* хоёрыг нэмээд 123 үсэг (буюу үе) болгожээ» (Дамдинсүрэн Ц., 1957, р. 112) гэж байхад, хоёр дугаар хэвлэлд «... дээр нь *ng un* хоёрыг нэмээд 123 үсэг/буюу үе/ болгожээ» (Дамдинсүрэн Ц., 1999, р. 150) гэж ойлгомжгүйгээр өөрчилсөн байна (үз Дамдинсүрэн 1999, р. 150).

- Монгол хэлний эгшиг фонемийн системд эр, эм саармаг эгшгийн чухал ролийг эн тэргүүн Чойжи-одсэр биш, харин Гунгаажалсан ажиглаж олсон. Түүний *Jirüken-ü Tolta* бол монгол хэлний авианы шинжлэлийн анхны бүтээл (р. 22).
- Чойжи-одсэр бол монгол хэлний авианы байршилтын хуулийг маш нарийн тодорхойлсон (р. 24).

Монгол авианы тухай *эр, эм, эрс* гэсэн гурван ангилалыг европын монголч нар, хэл тагнай хоёрын харьцаанд хамааруулж үздэг. Тэд, эр гэдгийг (мужский, задний, твердый) гэж, эм гэдгийг (женский, передний, мягкий) гэж орчуулдгийг Ш. Лувсанвандан шүүмжлээд, “эр гэдгийг сильный юмуу напряженный, эм гэдгийг слабый юмуу ненапряженный гэж орчуулсан бол үнэн байдалд илүү тохирох байжээ” (р. 28) гэж хэлэв. Тэрвээр өгүүлэлийнхээ төгсгөлдхи орос хураангуйд “... деление звуков монгольского языка на мужские и женские не зависит от положения языка (заднеязычный и переднеязычный) и неба (мягкий и твердый), а основывается на артикуляционной напряженности или не напряженности” (р. 47) гэж бичсэн юм.

2. 5. Билигүүндалайн “хөндлөн сэтгэлгэ”

Данзандагватай нэг үеийн (XVIII зуун) хүн, (төвөд-монгол) нэрт орчуулагч Билигүүндалай (Bilig-ün Dalai) “*Mongyol üsüg-ün Tolta-aca öcüken jiyaburi*”, “*Mongyol üsüg-ün ilyal ba taqabod-un öcüken tobci-nuyud bolai*” хэмээх хоёр судар гаргав. Түүний тэр зохиолуудын модон барын (өмнөт монголын хэв бололтой) хэвлэлийн гэрэл зурагийн хувь²⁴ (Балданжапов П. Б., 1962) гэдэг номд орсон (хавсралт) байна. Билигүүндалай өөрөөр сэтгэгч байсан бололтой. Тэр, „Сакяя Бандида Гунгаа-жалцаны зохиосон монгол үсгээр [шашин ном] эс дэлгэрээд самуун болсон”²⁵ гэж бичив. (*Olan qaγūcin bičig üd-tür Qutūy tu Blama [Saskya Bandita] mongyol üsüg-i jokiyaqui tere üsüg-iyer inü [Burqan-u šasin] ese delgereged samayun boluγsan-dur... – BILIG-ÜN DALAI, Mongyol üsüg-ün Tolta-aca öcüken jiyaburi bolai*, үзэмүү: БАЛДАНЖАПОВ П. Б., 1962, р.119: 2r.)

²⁴ Түүний зохиосон монгол бичгийн тухай хоёр жижиг судрыг П. И. Балданжапов гэрэл зураг татаж өөрийн номд нийтлэхдээ хооронд нь хутгалдуулсан юмуу эсвэл уг хоёр судар, уг хадгалагдан буй газраа (рукописный фонд БКНИИ, Улан-Удэ) холилдсон байсныг тэр анзаараагүй байж болох юм. Тэгээд судлагч, тэр хоёр номын судалгаа тайлбарыг бас хооронд нь хутгалдуулжээ (Балданжапов П. И., 1962, р. 8-10). Тэр хоёр судар чухал учир, анхдагч байдлаар нь үзэхийг хүсэгчдэд тусламж болгон доорхи залруулга би өгч байна:

1) *Mongyol üsüg-ün Tolta-aca öcüken jiyaburi bolai* гэсэн судрыг зөв уншъя гэвэл уг номын 106 дугаар талдхи судрын нэрийн дараа 107 дугаар талдхи судрын 1v. дугаартай талыг залган үзсэний дараа, уг номын 119 дүгээр талдхи судрын 2r. дугаартай талыг залгаж цааш уг номын 125 дугаар талыг дуустал үргэлжлүүлэн үзэх хэрэгтэй.

2) *Нөгөө Mongyol üsüg-ün ilyal ba taqabod-un öcüken tobci-nuyud bolai* гэдэг судрыг залруулан үзье гэвэл уг номын 118 дугаар талдхи судрын нэр ба 119 дүгээр талын дээд хэсэгтхи судрын 1v. дугаартай талыг залган үзсэний хойно, уг номын 107 дугаар талын доод хэсэгтхи судрын 2r. талыг залгаж цааш уг номын 116 дугаар талыг дуустал үргэлжлүүлэн үзвэл зохино.

Жич бас дурдууштай нь, Балданжаповын номын хавсралтад орсон судрын гэрэл зураг бүхий хэсэгт хуудасны дугаар тавьсангүй орхиод номзүй гэсэн хэсгээс худасны дугаар 127 гэж харагдах тул түүний өмнөх орхигдсон дугаарлалыг (10- - 126 дугаар тал) унших үзэх хүн санаандаа сэргээн байгуулж болно.

²⁵ самуун болсон (*samayun boluγsan*) гэдэг бол монгол хэлэнд дургүйцэх баймж санаатай, ноцтой хэллэг. Билигүүндалай, энэ судрыг бичихдээ эртний бичвэр олныг ашигласан гэсэн болохоор Сакяя Бандида Гунгаажалцаны тухай тэгж хэлэх үндэс түүнд байсан байж магадгүй. *Самуун болсон* гэдэг нь миний үзэхээр бол дундад үеийн монгол хэлнээ дөрвөн авиалбар болж нэгэнт ялгараад байсан уруулын авиануудад Гунгаажалцан, тусгай үсэг оноож өгсөнгүй (үзэмүү 1.5.1: зүүлт 12) явдалтай холбогдох бололтой. Харин Данзандагва бол тэр тухайд “цаг эс хүрсэн буюу уу, нөхцөл эс гарсаны тул монгол хэлээр ном орчуулсангүй байнам” (*Teyin atala čay ese kürgüsen buyu uu, нөкүцел эсе yaruγsan-u tula mongyol kelen-iyer nom орчйулуγсан үгеи байнам – Оутарγуй-yin Маһи 2, р. 4v.*) гэж зөөлөн хэлсэн юм.

Билигүүндалай, Чойжи-одсэрийн Цагаан Толгойн хоёр цэгтэй *hēth* ба *kāph* –ийг *γ/g* үсэг болгож өөрийн зохиолын хэвлэлд тууштай²⁶ нэвтрүүлэв. Энэ нь Данзандагвын журамлалаас эрс зөрүүтэй. Тэгээд өөрийн энэ зохиолыг “Богд Чойжи-одсэрийн монгол бичгийн Зүрхний Толгыг өчүүхэн товчлон ялгасан [энэ бичвэр]” (*Boγda Čhos-kyi- 'od-zer-ün jokiyāγsan Mongγol bičig-ün Jirūken-ü Tolta-yi öčügūken tobčilan iγāγsan egün-i...*) (BILIG-ÜN DALAI, *Mongγol üsüg-ün Tolta-ača öčūken jiyaburi bolai*, үзэмүү: БАЛДАНЖАПОВ П. Б., 1962, р. 5г.) гэж тодорхойлов. Түүний энэ жаахан сударт “Бандида Гунгаа-одсэр, урьдын үсгийн дээр *ša, pa, ja, ng* үсгүүдийг нэмж 123 үсэг болгосон”... (*Čhos-kyi- 'od-zer-ün jokiyāγsan jāγun nāγman üsüg...*, *Bandita Kun-dga'- 'od-zer ber urida-yin deger-e ša, pa, ja, ng üsüg-üd-i nemejü 123 üsüg bolγāγsan*) (BILIG-ÜN DALAI, *Mongγol üsüg-ün Tolta-ača öčūken jiyaburi bolai*, үзэмүү: БАЛДАНЖАПОВ П. Б., 1962, р. 7г, 7в.) гэх зэргийн Данзандагвынхаас маш өөр юмнууд бий. Данзандагва ба түүний “Огторгуйн Маань” –ийн тухай Билигүүндалай юу ч дурдаагүй нь анхаарлыг татна.

“Данзандагва *Oγtarγui-yin mani* зохиолоо 1727 оны орчим бичсэн (Балданжапов, 1962, р. 11), “Билигүүндалай, буддизмын гүн ухааны Бодичарияа аватара гэдэг судрыг 1748 онд монгол хэлнээ дахин орчуулсан” (Цэрэнсодном Д., 1987, р. 199) нэг үеийн сэхээтэнүүд юм. Ингээд тэр хоёр том ламын²⁷ мэргэжил адил, судлалын сэдэв²⁸ адил, тэр сэдвээр бичсэн зохиолоо бас хоёул Бээжингийн модон бараар²⁹ хэвлүүлсэн нь адил. Тийм байтал монгол үсгийн ялгах тэмдгийн талаар харилцан эсрэг баримтлалыг дэвшүүлж, цагаан толгойн дэг ялгарах үндсийг тавьцгаажээ. Гэвч тэр хоёр хоёул, ялгах цэгийг өөр өөрийн хоёр бүлэг үсэгт (Данзандагва: q/k), (Билигүүндалай: γ/g) тууштай тавьснаараа Гунгаа-одсэрээс ялгарна.

2. 6. Үсгийн “эндүүрлийн харанхуйг” нэмэгдүүлэхүй нь

Ном хувилах гол арга бол хуулан бичих³⁰ явдал байсан. Бусад дэгийн бичвэрийг хуулан бичихэд захиалагчийн хүслийн дагуу үсэгзүйн засвар хийх тохиол цөөнгүй гардаг байсан. Засан хуулагч бичээч, өөрийн сайн мэдэх үгсийн ялгах тэмдгийг хасах нэмэх зэргээр өөрчлөөд, утга эргэлзээтэй ба сэжигтэй үгсийн ялгах тэмдгийг уг байсан янзаар нь үлдээнэ. Ингээд “ялгах цэгүүдийг зөвхөн заримдаа, тохиолдлын чанартай, эсвэл дураараа тавьсан (еще чаще случается, что диакритические точки ставятся только иногда, случайно и произвольно

²⁶ Тайлагдал: Билигүүндалай, дэвсгэр *g* үсэгт хоёр цэгийг тавьсангүй, тэр тухайгаа тайлбар өгсөнгүй.

²⁷ *Том лам* Данзандагва бол *lharamba* гэдэг эрдмийн өндөр зэрэгтэй лам. Тө. *rab 'byams pa* (мо. *rabjamba*) үгчилбэл “маш хэтэрхий” (буддийн гүн ухааны доктор) хэмээх зэргийг Lhasa хийдэд хамгаалсан эрдэмтэн ламыг *lharamba < Lhasa rab 'byams pa* гэнэ. Билигүүндалай нь *Сун-жу-сы* (монгол сударт нь *Jingjusa*) сүмийн *Тэргүүн лам* хэмээх шашны өндөр мяндагтай лам нар байв. 19 дүгээр зууны нэрт хэл шинжлэлч Дандар Лхарамба, Данзандагвын *Огторгуйн Маанид* тулдуйдан *Хэлний Чимэгээ* бичиж, Данзандагвыг *мэргэдийн манлай* гэж нэн дээдлэн үнэлсэн мөртлөө үсэгзүйн хувьд Билигүүндалайн дэгийг дагасан юм.

²⁸ Судлалын сэдэв нь хоёуланд Чойжи-одсэрийн *Jirūken-ü Tolta* хэмээх журамласан хэлзүй.

²⁹ Билигүүндалайн товчилсон *Jirūken-ü Tolta* бас XVIII зууны үед Бээжинд модон бараар хэвлэгдсэн аж (үз Дамдинсүрэн Ц., 1957, р. 114).

³⁰ *Ном хуулан бичих* Хувийн юмуу хийдийнхээ номын санг баяжуулах гол арга нь номыг хуулан бичих, бичүүлэх явдал байжээ. Бурханы номыг хуулан бичих шиг дээд буян байхгүй гэсэн итгэл хүчтэй байв. Буян бодсон нэг хүн “Ганжуур” (108 боть) судрыг хуулан бичих ажлын дунд ороод хэвтэрт орсонд үлдсэн хэсгийн хагасыг зүүн хажуугаараа хэвтэн бичсэнд ташаа нь цоорч, үлдсэн хэсгийг баруун хажуугаараа хэвтэн бичиж дуусгасан” гэх хууч яриа байдаг. Санктпетербургийн их сургуулийн номын санд байгаа XVII зууны монгол бичмэл Ганжуурын ботиудыг үзэхэд тун олон хүний бичиг мэдэгдэж байсан. Хичээнгүй сайхан зурмын бичиг ихэнх боловч ур муутай, тун базаахгүй бичигтэй боть хэсгүүд цөөнгүй байсныг сонирхуулан тэмдэглэе.

– Владимирцов Б. Я., 1989, р. 76) нөм судар олширно. Нэгдүгээр (А.) ба хоёрдугаар (Б.) дэгийн бичвэрийг гуравдугаар (В.) дэгт шилжүүлэн хуулсан бичмэл, улмаар түүнийг хэвлэсэн бичвэрүүдэд ялгах тэмдгүүдийг журамгүй, дур зоргоороо тавьсан мэт харагдах нь ч аргагүй. Ингээд уг эхдээ эндүүрэлгүй байсан үг, “эндүүрэл гарахын орон” болж, тэр нь цааш гар дамжин хуулагдсаар бүүр өөр үг болон хувирч ч чадна.

XX зуунд хэвлэлд гарсан “*Jirüken-ü tolta-yin tayilburi*”-ууд (Позднеев, Пагва, Soyijalsürüing нарын нийтэлсэн хувилбарууд) бол нэгдүгээр дэгийн судрыг дэг (гол нь ялгах тэмдэг) холилдуулж хуулсан хэвлэлүүдийн жишээ болно.

3. Ялгах тэмдэг ба монгол бичгийн богдос

Монгол бичгээс төрсөн ойрадын тод үсэг (1648)³¹ болон садан төрөл уйгур, арабын бичигт *q* үсэг нь хоёр цэгтэй, сонгодогоос өмнөх монгол бичгийн дурсгалуудад хоёр цэгтэй *q* үсэг бүхий үгс цөөнгүй тохиолдож байгаа баримтуудаас үзэхэд ялгах тэмдэг – хоёр цэгийг *q* үсэгт тавьсан нь монгол бичгийн богдосын шинэ санаачилга арай биш байна.

Монгол бичгийн түүхийн гүний судлагч нэрт монголч Б. Я. Владимирцов, эртний уйгуржин монгол цагаан толгойд:

- *цэггүй hēth* үсгээр *q* авиаг (одоогийн халхын *x*),
- *цэгтэй ба цэггүй hēth* үсгээр *γ* авиаг (одоогийн халхын *z*),
- *kāph* үсгээр *k, g* авиаг (одоогийн халхын *x, z*)

тэмдэглэж байсныг хүснэглэн үзүүлсэн юм (Владимирцов Б. Я., 1989, р. 69). Тэр судалгаанаас үзвэл цэггүй *hēth* үсгийг бичих ба уншихад *q, γ* хоёр гийгүүлэгч хутгалдаж, *kāph* үсгийг бичих, уншихад *k, g* хоёр гийгүүлэгч хутгалдаж, зөв ойлгоё гэвэл зөвхөн хам бичвэрт тулгуурлах, таамаглах, бичлэгийг нүдлэн тогтоохоос өөр мэхгүй байсан хэрэг байжээ. Бурханы номын хэлний журамд ийм эндүүрэл байж болохгүй тул үсэгзүйд өөрчлөлт хийх шаардлага гарсан. Тэр өөрчлөлтийг бичгийн богдос тун хялбар аргаар хийв. Тэд, тухайн гийгүүлэгчдийн *эр* ба *эм*-ийг үл харгалзан, бичвэрт харагдах дүрээр нь ялгах үсэгзүйн зарчмыг баримталж, чанга *q, k* гийгүүлэгчийн өмнө хоёр цэг тавих, сул *γ, g* хоёрын өмнө хоёр цэг үл тавих журмыг гаргав. Ингэж эндүүрлийг хаасан нь богдосын шинэ санаачилга байжээ.

Сонгодог монгол болон одоогийн монгол бичигт зөвхөн *γ* (чухамдаа *γ* –ийн зарим) үсэг цэгтэй нь олон зуун жилийн уламжлал болохоор *q, k* үсэгт цэг байхыг үзсэн зарим судлагч түүнийг 17-р зуунд Бандида Гунгаа-одсэр гаргаж Данзандагвын шүүмжлэлээр засагдсан түр зуурын дутагдал гэж эндүүрсээр (2.2.2. хэсэгт үзнэ үү) байх тул хоёр цэгтэй *q* үсэг бүхий бичлэг чухамдаа анхдагч уламжлал байсан байж магадгүйг жишээгээр үзүүлье.

4. Ялгах тэмдэг ба монгол бичгийн эртний дурсгалууд

4.1. Бичиг баримтуудадхи хоёр цэг

(Доорхи жишээ үгсийг «Жанчив, 2006», «Ligeti, 1972» номуудад нийтэлсэн бичвэрүүдийн гэрэл зургаас латин галигт буулгав. Хоёр цэгтэй *q* үсгийг дээр нь зураас тавьж тэмдэглэв. Уг номд гэрэл зураг нь байгаа хуудасны тоог хаалтад бичив.)

³¹ “Зая-пандита создал свое письмо на основе уйгуро-монгольского алфавита.... графема *Q* с двумя точками, как в некоторых древнеуйгурских и среднемонгольских текстах, обозначает *X*” (Кара Д., 1972, р. 80).

- 1225 оны «Чингисийн чулуу» -ны бичигт (Жанчив, 2006, р. 114): *Buqa-sočiqai* 'Буха-сочихай' (газрын нэр);
- 1257 оны «Мөнх хааны хөшөө»-ний бичигт (ibid., р. 117): *bosqayul-* 'босхуул- /босгуул-'
- 1272 оны Нур ад-Дин-ий бичигт байгаа үгс (ibid., р. 225, l. 9): *aqa* 'ах', со. мо. аq-а ; Хүний нэрс: *Marqus, Taraqai* (ibid., р. 226, l. 27) Мархус, Тарахай; *Buqačar* (ibid., р. 226, l. 30) Бухачар; *Masqud* (ibid., р. 226, l. 49) Масхуд; *Iduqadai* (ibid., р. 227, l. 51) Идухадай; *Nasuqudliq* (ibid., р. 227, l. 52) Насухудлиг;
- 1289 онд Ил хан Аргунаас гоо Филипп-д илгээсэн захидалд (ibid., р. 216, l. 17): *Dimisq(i)* Дамаск (Ойрхи дорнотын хотын нэр);
- 1312 оны модон барын хэвлэлд (ibid., р. 192, l. 7, l. 9, р. 193, l. 6): *γaiqamšiy* 'гайхамшиг', *joqiyabai* 'зохиов', *qur-a* 'хур' (бороо);
- 1335 оны Чан Йин-жүйн гэрэлт хөшөөний бичээсэнд (Ligeti L., 1972): *taqīqu* (ibid., р. 39, l. 17) 'тахих', *soyurqal* (ibid., р. 47, l. 50) 'соёрхол', *usqal* (ibid., р. 43, l. 30) 'усхал /усгал', *čidaqui- ača* (ibid., р. 49, l. 54) 'чадах хирээр'
- 1346 оны Хар-Хорумын бичээсэнд (Ligeti L., 1972): *sayuqu balayasun* (ibid., р. 22, l. 2) 'суух орд балгас – residence', *γaqai jil* (ibid., р. 22, l. 6) 'гахай жил', *noqai jil* (ibid., р. 23, l. 11) 'нохой жил', *dabqur* (ibid., р. 23, l. 10) 'давхар', *asaraqu* (ibid., р. 23, l. 16) 'асрах', *adaliqbasu* (ibid., р. 23, l. 14) 'адалидхаваас /адилтгаваас', *ülü uqāqun* (ibid., р. 24, l. 19) 'үл ухагч';

Эртний бичвэрүүдэд хоёр цэгтэй *q* үсэг олон байвч тогтсон журамгүй, нэгэн үгэнд *q, y* хоёрт хоёуланд нь цэг тавьсан нь ч олон байна. Гэвч бичигчийн дур зоргын хэрэг биш, бичигчийн нүдний ойд уламжлалаар тогтсон утга соёлын буюу бичгийн үгст тавигдсан байгаа юм. Үүнээс үзвэл эрт нэгэн цагт тогтоод улмаар унтарсан нэг дүрэм журмын үлдэгдэл дурсгал аж. Турфаны цуглуулгын нэг цаглаварын бичвэрт "*ökin γarγaqūi*", "*ber bayulqūi*" гэсэн - *qūi* дагавартай тогтсон хэллэг, "...-baču/bečū joqīqu", "...-baču/bečū ülü joqīqu" гэсэн хэлзүйн загварыг хэдэн арван удаа эвдэлгүй бичсэн юм. Сар өдрийн сайн мууг заасан цаглавар бол утга соёлын хуучинсаг ертөнц болохоор тэр биз.

4. 2. Лу. Алтан Товч³² – ийн хоёр цэг

"Монголын Нууц Товчоон"-ы монгол бичгээр уламжилсан хувилбар³³ – "Лувсанданзаны Алтан товч"-д энэ асуудалд холбогдох чухал баримт байгааг энд дурдах нь чухалтай гэж үзэж байна. Шууд хэлбэл, Лувсанданзаны XVII зууны үед хуулан бичсэн Монголын Нууц Товчооны уйгуржин монгол бичгийн эх болсон эртний бичвэрт *q* үсэг, өмнөө хоёр цэгтэй байсны баримтууд юм.

Эх бичвэрийг дээдсийн таалдаг цэггүй үсэгт (*keb-ün üsiig* буюу Г. дэг) шилжүүлэн хуулах бол амархан юм. Гэвч Лувсанданзан, биеийн амрыг харалгүй, уншигчдын эндүүрлийг

³² XVII зууны монголын түүхийн сурвалжуудын дотор "Алтан Товч" – нэртэй судар хоёр байдаг. Том нь дэлгэрэнгүй, Нууц Товчоог бараг бүгдийг хуулан аваад цааши түүхийг XVII зуун хүртэл залган бичсэн. Түүнийг Лувсанданзаны Алтан Товч, хураангуйлан "Лу. Алтан Товч" гэж Монголын монголч нар нэрлэнэ. Нөгөө ном нь товчхон бага тул "Хураангуй Алтан товч" гэж нэрлэцгээдэг. Тэрнийг бас "Мэргэн Гэгээний Алтан Товч", "нэргүй Алтан Товч" гэх нь бий.

³³ "Лу. Алтан Товч"-ийг Монголын Нууц Товчооны уйгур-монгол бичгээр үлдсэн хувилбар мөн гэж бүрэн итгэж болно. Монголч Р. Pelliot, Б. Я. Владимирцов нар энэ асуудлыг дэвшүүлж С. Козин судалж, тэр хоёр номын холбогдох бүх бичвэрийг зэрэгцүүлэн нийтэлсэн (Козин С. А., Сокровенное сказание, М.-Л., 1941, 619 pp. : р. 321 – 399). Энэ хоёр номын зэргэцүүлэн нийтэлсэн бүүр сүүлийн үеийн ажлыг (Чоймаа Ш., 2002) үзэж болно.

хаахыг их хичээсэн нь мэдэгддэг. Тэгээд, утга санаа эргэлзээтэй, сэжигтэй (жишээ нь оноосон нэр) үгсийг уг эхэд байсан янзаар нь үлдээх, уншигч эндүү буруу уншихаас болгоомжлон зарим үгэнд “уртатгалын ү” үсэгт хоёр цэгийг нэмж тавих зэрэг ном хуулан бичихэд уламжлал болон тогтсон заншлыг дагасан байна. Ялангуяа оноосон нэрийн үгийн утга, хам бичвэрээс ч үл мэдэгдэх тул түүний хоёр цэгт *ḥēth* үсгийг *q*, *γ* хоёр үсгийн алинаар нь солин бичих вэ гэдэг бол үнэхээр төвөгтэй асуудал байжээ. Монгол номын хэлний журамлалт цагаан толгой гарахаас өмнөх үеийн монгол бичгийн үсэгзүйн баримтууд болж үлдсэн хоёр цэгтэй *q* үсэг бүхий үгсийн жишээг уг судрын гэрэл зургийн хэвлэлээс (*Lu. Altan Tobči*, 1990) галиглан үзүүлье :

- *Burqan qaldun* (p. 4v, уулын нэр), МНТ (§1, l. 4): *Burqan-Qaldun* ;
- *Uriyangqai* (p. 5r, овогийн нэр), МНТ (§ 9, l. 6): *Urjanqai* ;
- *Botaqan-Boγorjin* (p. 4v, голын нэр), МНТ (§106, l. 15): *Botoqan-Boγorzi*;
- *Olqunud* (p. 14r, овогийн нэр), МНТ (§ 54, l. 2): *Olqunūyud* ;
- *Qoqatai* (p. 15v, хүний нэр), МНТ (§ 70, l. 3): *Soqatai* ;
- *Jaq-a Gambuu* (p. 27v, хүний нэр), МНТ (§ 107, l. 10): *Žaqayambu* ;
- *Qalqajin aled* (p. 61r., газрын нэр), МНТ (§ 170, l. 8): *Qara-Qalžid eled* ;
- *Qal qaljid ald* (p. 68v, газрын нэр), МНТ (§214, l. 54): *Qalqalžid eled* ;

Оноосон нэрсийн жишээг цааш үргэлжлүүлж болно. Энэ зохиолд хоёр цэгтэй *q* үсгийг ердийн нэрийтгэл нэр үгэнд тавьсан нь ч (*ayiladq-a* ‘айлтга-’, *uq-a* ‘уха-’, *idq-a* ‘ятга-’, *darqala-* ‘дархала-’, *odqan* ‘отгон’, *soyurqal* ‘соёрхол’) олон бий юм. Үүний учир нь хуулан бичигч, цэгт *q* үсгийг мэдэхгүйдээ биш, үгийн утга санаанд эргэлзсэн ч биш, утга соёлын үгсийг (*ebüged-ün üges*) бичлэгий нь өөрчлөлгүй хэвээр нь үлдээх уламжлалыг дагасан хэрэг аж.

Тэдгээрээс эртний үсэгзүйн судалгаанд илүү сонин байж болох нэг жишээ бол *kituy-a* (халх. *хутга*) гэдэг үгний бичлэг юм. Энэ үг нэг хуудасны ар өвөрт долоон удаа (А. То. p. 68r, 68v) тохиолдоход Лувсанданзан эхний удаа санамсаргүй *kituy-a* (со. мо. Г. дэг) гэж хуулаад, долоон мөрийн дараа тохиолдсоноос нь эхлэн зургаан удаа *qituy-a*³⁴ (үз дагалт-9) гэсэн эртний бичлэгий нь зориуд үлдээсэн нь мэдэгдэнэ.

4. 3. “Хураангуй Алтан Товч”³⁵ –ийн хоёр цэг

XVII–XVIII зууны үед бичигдсэн түүхийн сурвалж *Хураангуй Алтан Товч* бол өмнөх үеийн баримт бичгүүдийг ашиглахдаа *q/γ* үсгийг цэггүй Г. дэгт тууштай шилжүүлэн хуулсан бичмэл юм. *Q,γ* үсэгт цэг тавьсан үгс энэ сударт таван хуруунд тоологдоно. Гэвч цөөн боловч олон юмыг хэлж байгаа баримт болно. Уг судрын гэрэл зургийн хэвлэлээс галиглан үзүүлье (*Quryiangyui Altan Tobči*, 2002):

³⁴ Монгол бичгийн дурсгалуудад байгаа хэлний хойгуурхи *i* эгшгийг зөвхөн нармайн *q/γ* гийгүүлэгчийн хамт байсан гэж судлагчид тэмдэглэдэг (Владимирцов Б. Я., 1989, p. 171). Гэтэл зарим эрдэмтэн, XVII зууныг хүртэлх бичгийн дурсгалуудад эр үгэнд байгаа *i* үсгийг *i* үсгээр галиглах учиртай гэж үздэг (Ринчен Б., 1966, p. 168).

³⁵ *Quryiangyui Altan Tobči* бол олон орны монголын судлалд алдаршсан сурвалж бичиг юм. Түүний зохиогчийг алдартай түүхч, зохиолч Урадын *Мэргэн Гэгээн* мөн гэж ихэнх судлагч үздэг. *Мэргэн Гэгээн*, ламын шашины сүм хийдийн хэлийг (уншилга, залбирал) монгол хэлээр явуулах эртний уламжлалыг сэргээж, шашиныг сүсэгтэнтэй нь амьдлгаар холбож өгсөн их гавьяат хутагт байсан. Түүний тухай (Цэрэнсодном Д., 1997) номоос дэлгэрүүлэн үзэж болно.

- *Qorildai Mergen* (p. 279: 4b), хүний нэр (МНТ., 1990, p. 13, § 8, l. 3.): *Qorilartai- Mergen*. Бичигч *Qorildai* гэдэг үгийг *Forildai* гэж буруу уншуулахгүйн тулд ялгах тэмдэг тавьжээ.
- *Dabqur quyay* (p. 307: 46b). *Dabqur* (халх. *давхар*) гэдэг үг бол бүхэнд ойлгомжтой энгийн үг. Бичигч, хуулахдаа хоёр цэгийг санамсаргүй тавиад, тэр үгийг долоон мөрийн дараа дахиад дайралдахад нь цэггүй бичиж «алдаагаа» зассан, *q̄* үсэгт хоёр цэг тавих заншил байдаг болохоор буруу уншигдахгүй гэж үзээд засалгүй үлдээсэн байдалтай.
- *Künggüi Jabaqan* (p.318: 63a), газрын нэр (халх. *Хүнгүй-Завхан*). *Q* гийгүүлэгчээр уншуулахын тулд хоёр цэг тавьжээ.
- *Jalyaqui* (p. 330: 82a), халх. *залгах*. Энэ нь бас бүхэнд ойлгомжтой энгийн үг. Сонирхолтой нь бичээч энд яагаад хоёр цэг тавихад хүрсэн нь түүний бичсэн зурдаснаас нь харагдана: Энэ үгийн бичилгэд монгол үсгийн нэр томъёогоор бол *долоон шүд* байх хэрэгтэй. Гэтэл бичээч санамсаргүй зургаан шүд биччихжээ. Бичвэрт “*алдсан төр, тасарсан шашиныг залгахын тулд*” (*aldaysan törü, tasuraysan šasin-i jalyaqui-yin tulada*) гэж байтал “*алдсан төр, тасарсан шашиныг залгахын тулд*” гэж уншигдахаар болжээ. “*Төр, шашиныг залха-*” гэсэн тун гэмт алдаа боллоо! Бичээч, тэр үгэнд нэг шүд нэмэх зай үгүй тул эцсийн хаягдсан шүдний харалдаа мөр хооронд нэг тодорхой шүд тавьжээ. Гэвч тэр засвар, санаанд нь хүрсэнгүй болохоор нөгөө оруулбар шүд, тухайт үг хоёрынхоо хоорондхи жаахан зайд бяцхан хоёр цэг тавьж *q̄* үсэг мөнийг нуталжээ (үз дагалт-10).

Бичээч, ингэж мөшгөлтөд орж мэдэх хүнд алдаанаас өөрийгөө аварсан аж. “Ялгах цэгүүдийг тохиолдлын чанартай, дур зоргоороо тавьдаг” (Владимирцов Б. Я., 1989, p. 76) гэсэн шүүмжлэлийн цаана ноцтой учир байсан бололтой.

Өгүүлэрүүн (Төгсгөл)

Толгойд хорин жил оршсон асуултын хариу болгож энэ өгүүллийг бичиж байна. Ерэн хэдэн оны эхээр үндэснийхээ бичгийг сэргээн хэрэглэх хөдөлгөөн ар монголд өрнөхөд урам төрөгдөн, монгол бичгийн ялгах тэмдгийг “урьдын багш нарын таалал” –ын дагуу, хялбар дөхөм аргаар улам тодорхой болгох аргыг эрэлхийлж, өөрийн саналыг “*Ācētü mongyol üsüg*” хэмээх нэгэн өгүүлэл болгож, сонгодог монголоор бичээд Өвөрмонголын юмуу Шинэжианы монгол хэл бичгийн судлалын сэтгүүлд нийтлүүлэхээр, 1991 онд өөрийн оюутан чех охидоор Дундад улсад илгээсэн билээ. Тэгээд тэр маань хэвлэлд гарсан эсэхийн мэдээ үгүй, хувийн баримт бичиг болон үлдсэн тул тэрнийг энэ өгүүлэлийн хавсралт болгон нийтэлж байна (үз дагалт-11).

XIX зууны эцэс, XX зууны эхэн үеc монгол хэл бичгийн судлалд “үг цөөн, утга тодорхой” бүтээлээ дэлгэсэн Хэшигтэн хошууны Бандида Deligjungnai (Дэлэгжунай)-н үгнээс (*Todudqayči toli*, 1927, p. 61): «... эрхин дээд мэргэдийн гаргасан монгол үсгийн нарийн нягт ёсонд, эгэл мунхаг бэртэгчин³⁶ ардын оюунаас халдсан гэмийн зүйлийг наманчилж... өөрийн ямар мэт ухсан утгыг хувь сацуу бусладаа тододховоос юун үл болох! хэмээх үлэмж саналаар...» (*Erkin degedü merged-ün yarγagsan mongyol üsüg-ün narin niyta yosun-dur, egel mungqay bertegčün arad-un oyun-ača qaldaysan gem-ün jüil-i namančilaju, ... öber-ün yambar metü uqaysan udq-a-yi qubi sačayu busud-a todudqabasu, yaγun ülü bolqu! kemekü ülemji sanal-iyar...*) төгсгөлийн үг болгов.

³⁶ “Эгэл хүн” гэсэн утгатай, самгарид > согд хэлнээс ирсэн үг. Эртний мо. бичигт *bartakjin* гэж бичсэний *k* үсгийг *g* үсгээр эндүүрэн уншсанаас *bertegčün* гэсэн эм үг болжээ (Владимирцов Б. Я., p. 135).

ЭШ АВСАН НОМЗҮЙ

- Bilig-ün Dalai 1: *Mongyol üsüg-ün Tolta-ača öčüken jiyaburi bolai*, (гэрэл зургийн хувь), үзэмүү: Балданжапов 1962, Приложения: !(p.107,lv.+ p. 119, 2r – p. 125).
- Bilig-ün Dalai 2: “*Mongyol üsüg-ün ilyal ba maqabod-un öčüken tobči nuγud bolai*” (гэрэл зургийн хувь), үзэмүү: Балданжапов 1962, Приложения: p. 119 (гэрэл зургийн 1v талын дараа p. 107, 2r – pp. 116 талуудыг залган үз).
- Čoyijalsürüng, D., 1968, *Mongyol qayučin bičig-ün ungsiqu bičig*, Ulaγanbaγatur, 266 pp.
- Lessing D., 1960, Lessing D. Ferdinand and Gombojav Hangin, *Mongolian-English Dictioyary*. University of California Fress, Berkeley and Los Angeles, 1217 pp.
- Ligti L., 1972, *Monuments préclassiques – 1, XIII^e et XIV^e siècles*, Budapest, 215 pp.
- Lu. Altan Tobči, 1990, *Altan Tobči, Erten-ü qad-un ündüsülegsen törü yosun-u jokiyal-i tobčilan quriγayсан Altan Tobči kemekü orušibai*, Эртний хаадын үндэслэсэн төр ёсны зохиолыг товчлон хураасан Алтан товч хэмээх оршвой, “The Golden Summary which relates briefly the deeds of civil governing established by ancient emperors” (The Mongol chronicle of the 17th century), Ulaγanbaγatur, 177 pp.
- Luvсандорž, 1995, *Základy mongolského písma a textová část*, Univerzita Karlova, Praha, pp. 186)
- Luvсандорj, J., 2005, The phonetics of foreignisms coming through Russian into present-day Mongolian, in *Mongolica Pragencia’05*, Edited by Jaroslav Vacek, Alena Oberfalzerová, Praha, p. 85 – 105)
- Оγтарγуй-γин Мағи –1: “*Jirüken-ü tolta-yin tayilburi – Üsüg-ün endegürel-ün qarangγuyi-yi arilyaγči Oγtarγuyi-yin Maғi kemekü orušiba*” (Бээжин барын судар, 17 pp., зохиогчийн цуглуулгад буй)
- Оγтарγуй-γин Мағи –2 : “*Jirüken-ü tolta-yin tayilburi – Üsüg-ün endegürel-ün qarangγuyi-yi arilyaγči Oγtarγuyi-yin Maғi kemekü orušiba*” (Буриадын Агийн Дацангийн модон барын судар, эхийн гэрэл зургийн хувь, 26 pp., үзэмүү: Балданжапов П. Б., 1962, p. 38 – 54)
- Оγтарγуй-γин Мағи –3 : “*Зүрхний тольтын тайлбар*”, ПАГВА, 1957, p. 40 – 54.
- SHM., 1990, В. Sumyabaatar, *The Secret History of the Mongols, transcription*, Ulaanbaatar, 965 pp.
- Todudqayči toli, 1927, *Lubsangčoyikor, Mongyol üsüg-ün youl yosun-u Todudqayči toli kemekü bičig*, үзэмүү: *Mongyol Kele Bičig - Өвөрмонголын Түүх хэлбичиг судлах газарын сэтгүүл*, Köke qota, №9, 1957, pp. 56 - 62).
- Quriγangγui Altan Tobči, 2002, *Qad-un ündüsün-ü quriγangγui altan tobči*, Эх бичгийн судалгаа хийсэн Ш. Чоймаа, Улаанбаатар, 331 pp.

* * *

- Владимирцов, Б. Я., 1925, *Монгольский сборник рассказов из Рајсатантра* (үзэмүү: Сборник музея антропологии и этнографии, Том V, вып. 2, Ленинград, p.: 401 – 452)
- Владимирцов, Б. Я., 1989, *Сравнительная грамматика монгольского письменного языка и халхаского наречия*, издание 2-е, Москва, 437 pp.
- Балданжапов, П. Б., 1962, *Jirüken-ü tolta-yin tayilburi – монгольское грамматическое сочинение XVIII века*, Улан-Удэ, 136 pp.
- Балданжапов, П. Б., 1962b., *Kelen-ü сітег – монгольское грамматическое сочинение XIX века*, Улан-Удэ, 134 pp.
- Гомбожав, С., 2005, *Монголчуудын түвд хэлээр зохиосон зохиолын зүйл*, Улаанбаатар, 60 pp.
- Дамдинсүрэн, Ц., 1957 *Монголын уран зохиолын тойм*, Улаанбаатар, 264 pp.
- Дамдинсүрэн, Ц., 1999, *Монголын уран зохиолын тойм*, нэмж дэлгэрүүлсэн Д. Цэрэнпил, Улаанбаатар, 158 pp.
- Кара Д., 1972, *Книги монгольских кочевников (семь веков монгольской письменности)*, Москва, 193 pp., + 26 таблицы.
- Жанчив, Ё., 2006, *Сонгодог монгол бичгийн өмнөх үеийн дурсгалууд*, Улаанбаатар, 241 pp.

- Лувсанвандан, Ш., 1965, *Эртний монгол хэлний фонемийн систем нь*, үзэмүү: *Монголын судлал*, Tomus V, Улаанбаатар, р.3 – 47.
- Пагва, Т., 1957, “*Зүрхний тольтын тайлбар*” –ыг судалсан тухай тэмдэглэл, Улаанбаатар, 64 pp.
- Рамстедт, Г. И., 1967, *Монгол ном бичгийн хэл, Хүрээний аман аялгуу хоёрыг авианзүйгээр харшуулсан нь* (монгол орчуулга < *Das Schriftmongolische und die Urgamundart Phonetisch verglichen*, von G. J. Ramstedt), үзэмүү: Хэл зохиол, 4-р боть, Улаанбаатар, 1967, р. 112 – 174.
- Ринчен, Б., 1966, *Монгол бичгийн хэлний зүй*, дэд дэвтэр – авиан зүй, Улаанбаатар, 403 pp.
- Сазыкин, С. А., 1998, *Каталог монгольских рукописей и ксилографов Института Востоковедения АН СССР.*, Том I, Москва.
- Төмөртоого, Д., 2002, *Монгол хэл шинжилэлийн онол түүхийн асуудлууд*, Улаанбаатар, 549 pp.
- Цэвэл, Я., 1966, *Монгол хэлний товч тайлбар толь*, Улаанбаатар, 911 pp
- Цэрэнсодном, Д., 1987, *Монгол уран зохиол (XIII – XVIII зууны эх)*, Улаанбаатар, 438 pp.
- Цэрэнсодном, Д., 1997, *Монголын бурхан шашины уран зохиол*, Улаанбаатар, 491 pp.
- Чоймаа, Ш., 2002, “*Монголын Нууц товчоон*”, Лувсанданзаны “*Алтан товч*” эхийн харьцуулсан судалгаа, Улаанбаатар, XII + 187 pp.
- Шагдарсүрэн, Ц, 2001, *Монголчуудын үсэг бичигийн товчоон* (үсэгзүйн судалгаа), Улаанбаатар, 300 pp.
- Шагдарсүрэн, Ц, 2007, *Эх хэлээ эвдэхгүй юм сан...*, Улаанбаатар, 215 pp.

Дагалт – 1.

“Монгол үсэгзүйн Цагаан Толгойн дэг” гэсэн хэсэгт ярьсан ялгах тэмдэг–цэгийн хэрэглээг үзүүлсэн хүснэгт

ҮСЭГИЙН НЭР	МОНГОЛ ҮСЭГ			ЦАГААН ТОЛГОЙН ДЭГҮҮД			
	эхэнд	дунд	адагт	А. дэг (Гүнгаа- жалцан, Чойжи- одсэр, Данзан- дагва)	Б. дэг (Билигүүн- далай)	В. дэг (Гүнгаа- одсэр)	Г. дэг (хэвийн үсэг)
хоёр цэгтэй <i>hēth</i>	ᠬᠡ	ᠬᠢ	ᠬᠤ	q	γ	γ	
	ᠬᠡ	ᠬᠢ	ᠬᠤ	qa	γa	γa	
	ᠬᠡ	ᠬᠢ	ᠬᠤ	qo qu	γo γu	γo γu	
цэггүй <i>hēth</i>	ᠬ	ᠬ	ᠬ	γ	q	q	γ q
	ᠬ	ᠬ	ᠬ	γa	qa	qa	γa qa
	ᠬ	ᠬ	ᠬ	γo γu	qo qu	qo qu	γo γu qo qu
хоёр цэгтэй <i>kāph</i>	ᠬᠢ	ᠬᠢ	ᠬᠤ	k	g		
	ᠬᠢ	ᠬᠢ	ᠬᠤ	ke	ge		
	ᠬᠢ	ᠬᠢ	ᠬᠤ	ki	gi		
	ᠬᠢ	ᠬᠢ	ᠬᠤ	kō kü	gō gü		
цэггүй <i>kāph</i>	ᠬ	ᠬ	ᠬ	g	k	g k	g k
	ᠬ	ᠬ	ᠬ	ge	ke	ge ke	ge ke
	ᠬ	ᠬ	ᠬ	gi	ki	gi ki	gi ki
	ᠬ	ᠬ	ᠬ	gō gü	kō kü	gō gü kō kü	gō gü kō kü
цэгтэй <i>nūn</i>	ᠨ	ᠨ	ᠨ	n	n		

	ᠨ	ᠨ	ᠨ	na ne	na ne		
	ᠨ	ᠨ	ᠨ	ni	ni		
	ᠨ	ᠨ	ᠨ	no nu	no nu		
	ᠨ	ᠨ	ᠨ	nö nü	nö nü		
цэггүй <i>nīn</i>	ᠨ	ᠨ	ᠨ			n	n
	ᠨ	ᠨ	ᠨ			na ne	na ne
	ᠨ	ᠨ	ᠨ			ni	ni
	ᠨ	ᠨ	ᠨ			no nu	no nu
	ᠨ	ᠨ	ᠨ			nö nü	nö nü
хоёр цэгтэй <i>šin</i>	ᠨ	ᠨ		š	š	š	š
	ᠨ	ᠨ	ᠨ	ša še	ša	ša	ša
	ᠨ	ᠨ	ᠨ	ši	ši		
	ᠨ	ᠨ	ᠨ	šo šu	šo šu	šo šu	šo šu
	ᠨ	ᠨ	ᠨ	šö šü	šö šü	šö šü	šö šü
цэггүй <i>šin</i>	ᠨ	ᠨ	ᠨ	s	s	s	s
	ᠨ	ᠨ	ᠨ	sa se	sa se	sa se	sa se
	ᠨ	ᠨ	ᠨ			ši	ši
	ᠨ	ᠨ	ᠨ	so su	so su	so su	so su
	ᠨ	ᠨ	ᠨ	sö sü	sö sü	sö sü	sö sü

Дагалт – 2А.

Монгол үсгийн эх болсон согд-уйгур үсгийн галиг, нэр томьёо

а) Шагдарсүрэн 2001, р. 44.

Согд арван дөрвөн үсгийн толгойг
латинаар үсэгчлэн буулгах ёсон

No.	Үсгийн махбод	үсэгчилэн буулгах галиг	галигийн нэр
01	ᠠ	' (/ \')	áleph
02	ᠡ	y (i ²)	yod
03	ᠢ	w	waw
04	ᠨ	n	nún
05	ᠬ	k	kápt
06	ᠶ	y	héth
07	ᠮ	p (b ³)	pé
08	ᠰ	s	śín
09	ᠲ ᠳ	t / δ (d ⁴)	taw, dáleth
10	ᠯ	l	lámeth
11	ᠮ	m	mém
12	ᠴ	c (č ⁵)	sádhé
13	ᠷ	r	rés
14	ᠮ	v	béth

Дагалт – 2Б.

б) Владимирцов, 1989, р. 71.

ТАБЛИЦА VI
уйгурско-монгольский алфавит.

Названия букв и их механическая транслитерация согласно основному значению		Начальные	Средние	Конечные	Древнее значение	Современное халхаское произношение
āleph	'	⦿	⦿		a	а ä
—	'	⦿	⦿		e	е ё ö ü
yod	y	⦿	⦿	⦿	i i	i
waw	w	⦿	⦿	⦿	o u	о у
—	w	⦿	⦿	⦿	ö ü	ö ü
nūn	n	⦿	⦿		n	н
nūn + kāph	nk		⦿	⦿	ng	ң
ḥeth	γ	⦿	⦿		q > x	х
—	γ	⦿	⦿	⦿	γ q	в г γ k
pē	p	⦿	⦿	⦿	p b w	б w ḡ w n
šin	š (s)	⦿	⦿	⦿	s	с
—	š	⦿	⦿		š	ш
taw, dāleth	t δ	⦿	⦿	⦿	t d	т' д
lāmedh	l	⦿	⦿	⦿	ll	л л l l
mēm	m	⦿	⦿	⦿	m	м
ṣādhē	č	⦿	⦿	⦿	č j	ц' ч' з ц
yod	y	⦿	⦿	⦿	j y	з ц j
kāph	k	⦿	⦿	⦿	k g	х' x γ γ k
rēš	r	⦿	⦿	⦿	r	р р р р
beth	β	⦿	⦿		v w	w

Дагалт – 3.

гэдэс+шүд/сүүл (1.1.)

гэдэс (ᠭ) + шүд (ᠰ) – дундхи дэвсгэр d (ᠳ)

гэдэс (ᠭ) + сүүл (ᠰ) – адагтхи дэвсгэр d (ᠳ')

гэдэс	ᠳ	ᠳ	гэдэс	ᠳ	ᠳ
шүд	ᠰ		сүүл	ᠰ	

Дагалт – 4.

2.1: (Todudqayči toli, 1927, p. 58):

ᠨᠢᠶᠢᠨᠲᠤᠭᠠᠢᠨ

ᠶᠠᠯᠠᠭᠠᠨ

(qālaqun)

(yalaqun)

ᠨᠢᠶᠢᠨᠲᠤᠭᠠᠢᠨ

ᠶᠠᠯᠠᠭᠠᠨ

ᠶᠠᠯᠠᠭᠠᠨ


ᠶᠠᠯᠠᠭᠠᠨ

ᠶᠠᠯᠠᠭᠠᠨ

ᠶᠠᠯᠠᠭᠠᠨ

Дагалт – 5.

Бандида Гунгаа –одсэрийн шинэ *Jirüken-ü tolta* – ийг шүүмжилсэн нь (2. 2. 1.)



Дагалт - 6.



“ПАГВА 1957” номд хавчуулсан залруулга (2. 2. 2)

„Зүрхний тольтын тайлбарын“ хэвлэлийн зарим залруулга.

Хуудас	Мөр	Ташаарсан нь	Залруулах нь
9	4	бүтүүлэг	битүүлэг
14	37	НА-нөхцөлийг	АА-нөхцөлийг
18	16	ГА ха	ха ГА
19	39	ГА ха	ха ГА
44	15	хуваасн нь	хавьяагсан нь
46	20	айлтгахын	айлдахын
46	24	айлтгахуй	айлдахуй
50	4	Г А	ха
50	5	ХА	Г А
50	6	ГА	ХА
50	7	ХА	ГА
52	18	ВА	Б А
24	8	ᠮᠠᠨᠠᠭ	ᠮᠠᠨᠠᠭ
25	13	ᠮᠠᠨᠠᠭ	ᠮᠠᠨᠠᠭ
27	8	ᠮᠠᠨᠠᠭ	ᠮᠠᠨᠠᠭ
27	8	ᠮᠠᠨᠠᠭ	ᠮᠠᠨᠠᠭ
28	19	ᠮᠠᠨᠠᠭ	ᠮᠠᠨᠠᠭ
29	3	ᠮᠠᠨᠠᠭ	ᠮᠠᠨᠠᠭ
29	9	ᠮᠠᠨᠠᠭ	ᠮᠠᠨᠠᠭ
29	9	ᠮᠠᠨᠠᠭ	ᠮᠠᠨᠠᠭ
29	10	ᠮᠠᠨᠠᠭ	ᠮᠠᠨᠠᠭ
29	10	ᠮᠠᠨᠠᠭ	ᠮᠠᠨᠠᠭ
29	13	ᠮᠠᠨᠠᠭ	ᠮᠠᠨᠠᠭ
29	15	ᠮᠠᠨᠠᠭ	ᠮᠠᠨᠠᠭ
29	19	ᠮᠠᠨᠠᠭ	ᠮᠠᠨᠠᠭ
31	3	ᠮᠠᠨᠠᠭ	ᠮᠠᠨᠠᠭ
31	8	ᠮᠠᠨᠠᠭ	ᠮᠠᠨᠠᠭ
32	17	ᠮᠠᠨᠠᠭ	ᠮᠠᠨᠠᠭ
34	3	ᠮᠠᠨᠠᠭ	ᠮᠠᠨᠠᠭ
35	7	ᠮᠠᠨᠠᠭ	ᠮᠠᠨᠠᠭ
35	13	ᠮᠠᠨᠠᠭ	ᠮᠠᠨᠠᠭ
36	1	ᠮᠠᠨᠠᠭ	ᠮᠠᠨᠠᠭ
37	15	ᠮᠠᠨᠠᠭ	ᠮᠠᠨᠠᠭ
39	6	ᠮᠠᠨᠠᠭ	ᠮᠠᠨᠠᠭ
39	20	ᠮᠠᠨᠠᠭ	ᠮᠠᠨᠠᠭ

Дагалт – 7А.

“Oyтарыуи-yin Майи –2” (Агийн Дацангийн хэвлэл) хэмээх судартхи монгол үсгийн Цагаан толгой (Балданжапов, 1962, р.42 - 43)



Дагалт – 7Б.

Уг судартхи “үсэг зассан ёсон” гэсэн хэсгийг Балданжапов орос орчуулгадаа латин үсгээр галиглан үзүүлсэн байдал (Балданжапов, 1962, р. 69)

Суть первого [подраздела]: Богдо с целью устранения отсталости и темноты народа, развернув свое орхимджа³¹ под солнечными лучами, проникающими в юрту, и проявив свой талант, создал следующие буквы:



a > o, u*
e > ö, ü

na > no, nu	ra > ro, ru	ja > jo, ju
ne > nö, nü	re > rö, rü	je > jö, jü
ba > bo, bu	sa > so, su	
be > bö, bü	se > sö, sü	
ga > go, gu	da > do, du	
ge > gö, gü	de > dö, dü	
xa > xo, xu	ta > to, tu	
ke > kö, kü	te > tö, tü (᠑a)	
ma > mo, mu	ya > yo, yu	
me > mö, mü	ye > yö, yü	
la > lo, lu	ca > co, cu	
le > lö, lü	ce > cö, cü	

* Буквально: от "а" образовал "о, и" и далее соответственно.

Дагалт – 7В.

Oyugui-yin Maii 2 сударт монгол үсгүүдийн хажууд төвд үсэг хадаж буруу унших эндүүрэлийг хаасан нь (2.2.4.1.)



Төвөд үсэг хадсан байдлын зарим жишээ

Төвөд үсэг хадсан нь:

	Монгол үсэг	Хадсан төвөд үсэг
цэгтэй <i>q, k</i>	ᠠᠨ ᠨ	ᠠ
цэггүй <i>y, g</i>	ᠨ ᠨ	ᠨ
хэвтээ <i>d</i>	ᠳ	ᠰ
босоо <i>l</i>	ᠯ	ᠯ
ᠥ үсэг	ᠡ	ᠡ
<i>j</i> үсэг	ᠵ (ᠴ)	ᠵ

Дагалт – 8.

Oyugui-yin Maii 1 (Бээжин барын хэвлэл), *Oyugui-yin Maii* 2 (Агийн Дацангийн хэвлэл) хэмээх судруудад *d, t* хоёр үсгийг дүрсээр ялгасан нь (2. 2. 4. 1)

Латин галиг	Үсгийн байрлал	Дүрсээр үл ялгасан (сонгодог монгол бичигт)	
d	үгийн эхэнд	ᠳ	ᠳ
	үгийн дунд	ᠳ	ᠳ
	үгийн эхэнд	ᠳ	ᠳ
	үгийн дунд	ᠳ	ᠳ


Дагалт – 9.

“хутга” гэсэн үгний бичилгэ (*qituy-a*), үзэмүү 4.2.



Дагалт – 10.

4.3: “*Quriyangyui Altan Tobci*” сударт “*jalyaqui*” гэдэг үгний алдааг зассан нь



- 3 -

1. 4. Дорж
 2. Дорж 4. Дорж
 3. Дорж А. Дорж
 4. Дорж Т. Дорж
 5. Дорж У. Дорж
 6. Дорж В. Дорж
 7. Дорж У. Дорж
 8. Дорж 0. Дорж

9. Дорж
 10. Дорж
 11. Дорж
 12. Дорж
 13. Дорж
 14. Дорж
 15. Дорж
 16. Дорж
 17. Дорж
 18. Дорж
 19. Дорж
 20. Дорж

- 4 -

А Э И О У О У
 1. 2. 3. 4. 5. 6. 7.

1. Дорж
 2. Дорж
 3. Дорж
 4. Дорж

ШВЕД
 ТАНХИМ
 ТАНХИМ
 ТАНХИМ

1. Дорж
 2. Дорж
 3. Дорж
 4. Дорж

-5-

- | | | | | | | | |
|-----|-----------|-----|----------|-----|-----|-----|-----|
| 8. | Г Н | 15. | Г О | 22. | Г Р | 29. | Г Г |
| 9. | Д Б | 16. | Г Ш | 23. | Г В | 30. | Г Э |
| 10. | Д П | 17. | Р Т | 24. | Ф Ф | 31. | Ф Ж |
| 11. | ХА, ХБ ХЭ | 18. | Ф Д | 25. | М З | | |
| 12. | ГГА, ГГБ | 19. | Ч Ч, Ч Ц | 26. | М Ц | | |
| 13. | Г М | 20. | А Ж, А З | 27. | Д К | | |
| 14. | Г Л | 21. | А Й | 28. | А Х | | |

-6-

18. ...
 19. ...
 20. ...
 21. ...
 22. ...
 23. ...
 24. ...
 25. ...
 26. ...
 27. ...
 28. ...
 29. ...
 30. ...
 31. ...

-14-

14. *Handwritten text in Mongolian script, starting with '14. ...'*
 15. *Handwritten text in Mongolian script, starting with '15. ...'*
 16. *Handwritten text in Mongolian script, starting with '16. ...'*

-15-

1991. 08. 5.
Handwritten text in Mongolian script, including a date and several lines of text.